



THE UNIVERSITY OF BRITISH COLUMBIA

School of Public Policy and Global Affairs

УУРХАЙН ЭРТ ҮЕ ШАТАНД ОРОН НУТАГТ
ҮНЭ ЦЭНИЙГ БИЙ БОЛГОЖ ХУВААЛЦАХ:

“ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ”-ИЙН КЕЙС



СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2018 он

Доктор. Жоселин Фрейзер
Докторын дараах судлаач
Нийгмийн Бодлого, Олон Улсын
Харилцааны Сургууль

Батдоржийн Булган
Судлаач
Норман Б. Кийвэл Уул Уурхайн
Инженерийн Сургууль

Доктор. Надя Күнз
Туслах Профессор
Норман Б. Кийвэл Уул
Уурхайн Инженерийн Сургууль
Нийгмийн Бодлого, Олон Улсын
Харилцааны Сургууль

ХУРААНГУЙ

Бритиш Колумбын Их Сургуулийн судалгааны баг нь хайгуулын компаниуд үйл ажиллагаа явуулж буй улс орон болон орон нутагт эрдэс баялгийн үр өгөөжийг хэрхэн нэмэгдүүлэх боломжтойг судлах судалгааны төслийг 2017 оны арван нэгдүгээр сараас эхлэн 2018 оны долдугаар сарын хооронд гүйцэтгэлээ. Судалгаанд “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс”) -ийг кэйс болгон хамруулсан болно. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг, Канад Улсад бүртгэлтэй, ашигт малтмал хайгуулын компани юм. Тус кейсийн судалгааны үндсэн зорилтууд нь:

1. Бизнесийн болон нийгмийн давхцаж буй асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг хамтран ажиллах замаар шийдвэрлэснээр нийтлэг үнэ цэнийг бий болгож, хуваалцах;
2. Орон нутгийн болон олон улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг үйл ажиллагааны стратегид нэгтгэх.

“Нийтлэг үнэ цэнэ бий болгох” гэсэн нэр томьёо нь макро эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн эдийн засгийн стратеги бөгөөд бизнес, нийгэмд нэгэн зэрэг ашиг тустай үр дүнд хүргэх зорилготой юм (Портер & Крамер, 2011). Хэдийгээр “нийтлэг үнэ цэнэ бий болгох” гэдэг нь хүмүүст өөр өөр утгатай байж болох боловч дээр дурдсан тодорхойлолт нь уурхайн мөчлөгийн эхэн үе шатан дахь боломжит үр өгөөж нөлөөллийн талаар ойлголт авахад суурь болно.

UBC-ийн баг нь холимог судалгааны аргачлал ашигласан. 2017 оны 1-р сараас 2018 оны 6-р сар хүртэлх хугацаанд бичиг баримтын судалгааг хийсэн бөгөөд Эрдэнэ Ресурсийн хэвлэл мэдээнд судалгаа шинжилгээ хийн эхэлсэн. Судалгааны баг тусгайлан сонгосон 38 хүнтэй биечлэн ярилцлага хийсэн. Үүнээс гадна таван оролцогч бүхий нэг бүлгийн ярилцлага хийсэн. Канад болон Монгол Улсад буй Эрдэнэ Ресурсийн гол оролцогч талуудын бүлгүүд ярилцлагад хамрагдсан. Үүнд компанийн төлөөлөгчид, салбарын түншүүд, нөлөө бүхий оролцогчид, иргэний нийгэм болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээлэл, хөрөнгө оруулагчид, орон нутгийн засаг захиргаа, олон нийтийн төлөөлөгчид, малчин өрхүүд багтана.

Судалгааны үр дүнд Эрдэнэ Ресурсийн орон нутгийн оролцоог хангах арга барил нь компани болон түүний оролцогч талуудад эерэг үр дүнг авчирсан гэж дүгнэсэн. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь Эрдэнэ Ресурс нь төсөл төлөвлөлтийн шатанд орон нутгийн эрэлт хэрэгцээнд анхаарч, орон нутгийн оролцоог хангах итгэл хүлээсэн гэж үзжээ. Гэсэн хэдий ч, малчид Баянхонгор аймагт ашигт малтмал олборлох, уурхайн үйл ажиллагаа явуулж буйд санаа зовж байгаагаа илэрхийлсэн. Энэ нь голчлон усны хүртээмжийн асуудлаас үүдэлтэй байна. Тэдний амьжиргаа мал сүрэг, говийн бэлчээрээс

хамааралтай учраас уурхайн үйл ажиллагаа байгаль орчинд хэрхэн нөлөөлөх вэ гэдэг нь анхаарах гол асуудал юм. Малчдын үзэл бодол нь зөвхөн Эрдэнэ Ресурсд хамааралтай бус, харин уул уурхайн салбарт ерөнхийд нь чиглэсэн байна.

Хөндлөнгийн оролцогч талуудын 25 орчим хувь нь Эрдэнэ Ресурсийн усны менежментийн ажлын талаар мэдээлэлтэй байсан. Мөн оролцогч талууд компаниас 2012 онд эхлүүлсэн урт хугацааны тэтгэлэгт хөтөлбөр орон нутагт бүтээсэн үнэ цэнийн талаар дурдсан байна. Энэ тэтгэлэг нь орон нутгийн ахлах сургууль төгсөгчдийн их, дээд сургуульд суралцах зардлыг санхүүжүүлдэг. Ярилцлагад оролцогчид “Баян Хөндий” төсөлд ойрхон байдаг хоёр сумын оршин суугчдад компанийн хувьцаа эзэмших боломжийг бий болгож байгаа шинэ санаачлагын ач холбогдлыг онцлон тэмдэглэсэн. Эрдэнэ Ресурс нь Монголын хөрөнгийн бирж дээр 2018 оны 6-р сард үнэт цаасыг давхар бүртгүүлэн, орон нутгийнханд хувьцаа санал болгосон. Энэхүү санаачилгыг бүс нутгийн оролцогч талууд уул уурхайн олборлолтоос үнэ цэнийг бий болгож, хуваалцах үндсэн шинж гэж үзэж байна.

Судалгаагаар хайгуулын компаниуд нь үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа үнэ цэнийг бий болгон хуваалцах эхлэлийг тавих боломжтой гэж дүгнэжээ. Эрдэнэ Ресурс нь орон нутагт явуулж байгаа үйл ажиллагаагаар танигдсан. Тус компанийн амжилт нь дараах дөрвөн үндсэн хүчин зүйлээс хамаарч байна. Үүнд:

1. Захирлуудын зөвлөл, дээд удирдлага болон нийт ажилтнуудын тогтвортой хөгжлийн ач холбогдлыг өндөрт өргөн хамгаалдаг **алсын хараа**
2. Тогтвортой үр дүнд хөтлөх **бизнесийн стратеги**
3. Оролцогч талуудтай эрүүл, **бат бөх харилцааг** бий болгох эрмэлзэл.
4. **Иргэдэд чиглэсэн үйл ажиллагаа**, орон нутагтай хамтарч ажиллахдаа зөв хүмүүсийг ажиллуулах, мөн орон нутагтай хамтран ажиллах стратеги нь бизнес үнэ цэнийг бий болгодог гэдгийг хүлээн зөвшөөрөх.

Энэ судалгааны төслийн хүрээнд, компаниуд нийгмийн зөвшөөрлийг авахад хэрэгжүүлэх нийгмийн хариуцлагын үе шатлалууд болон хэрэгжүүлж болох санаачилгуудын талаар цаашид үргэлжлүүлэн хамтран судалж болох сэдвүүдийг гаргаж тавьсан. “Баян Хөндий” болон “Алтан Нар” төслүүдээ цаашлуулан судалж байгаа энэ үеийг даган Эрдэнэ Ресурсийн кэйсийг судалбал эрдэм шинжилгээний судлаачид, салбар болон засгийн газарт ашигт малтмал, хайгуулын компаниуд уурхайн мөчлөгүүдэд оролцогч талуудтай харилцаагаа хэрхэн бий болгож хамгаалан, шаардлагатай өөрчлөлтийг хийж ирсэн талаар нэмэлт мэдээллүүдийг өгөх боломжтой болно.

ОЙЛГОЛТ, НЭР ТОМЪЁ, ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

Нийтлэг үнэ цэнэ (CSV) бий болгох: Бизнес болон нийгэмд аль алинд ашиг тустай үр дүнд хүргэх ашиг сонирхлын цэгүүдийн огтлолцлыг олоход чиглэсэн менежментийн стратеги

Компанийн нийгмийн хариуцлага (CSR): Компанийн нийгмийн хариуцлага

NVivo: Чанарын шинжилгээг гүйцэтгэхийн тулд дэвшилтэт мэдээллийн менежмент, асуулга, дүрс бичлэгийн хэрэгслүүдийг ашигладаг программ хангамж

Эх сурвалжийн дуу хоолойн эзлэх хувь: Хэвлэл мэдээллийн контентод компанийн албан төлөөллийг шууд иш татсан байх

Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл: Засгийн газар, Орон нутаг болон бусад оролцогч талууд эсвэл сонирхогч талууд компанийн бизнесийн үйл ажиллагаа, журмуудыг хүлээн зөвшөөрсөөр байх

VCP: Усны Сайн дурын ажиллагааны кодекс

Factivia: Dow Jones-д харьяалагддаг мэдээллийн хайлтын сан/систем бөгөөд 30,000 орчим мэдээний агентлагуудаас контент хүлээн авдаг

ОУСК: Олон улсын санхүүгийн корпораци

МХБ: Монголын хөрөнгийн бирж

ОРШИЛ

Уул уурхайг Монгол Улсын одоогийн болон ирээдүйн эдийн засгийн өсөлтийн үндсэн багана гэж үздэг. Гэхдээ энэ салбарын хөгжил дэвшил, тэлэлт нь байгаль орчны менежмент, нийгмийн нөлөөлөл болон үр ашиг хуваах тал дээр орон нутгийн ард иргэд болон олон нийтийн дунд хурцадмал байдлыг үүсгэж байна. Уул уурхайн үйл ажиллагааны шууд нөлөөнд өртсөн иргэд уул уурхайн үр шим нийгэм болон байгаль орчинд үзүүлсэн хохирлоос давна гэж итгэхгүй байгаагаас энэхүү хурцадмал байдал үүсч байна.

Уул уурхай нь Монгол Улсын Өмнө говийн бүс нутагт хамгийн их хурдацтай хөгжиж тэлж байгаа бөгөөд хүн ам сийрэг суурьшсан, цөлийн энэ бүсэд зэс, алт, нүүрс зэрэг ач холбогдол бүхий ашигт малтмал бий. Тус бүс нутагт найдвартай эрчим хүч, ундны ус болон бусад чухал дэд бүтэц хязгаарлагдмал байгаа нь компаниуд ашигт малтмалын хайгуулаас уурхай болгон төслүүдээ урагшлуулан хөгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. Хэдийгээр уул уурхайн төсөл нь хэрэгцээтэй дэд бүтцийн хөгжлийг бий болгосон ч орон нутгийн малчин иргэд байгаль орчны бохирдол, малчин аж ахуйд сөрөг нөлөөтэй гэсэн байр суурьтай байна. Монгол Улсын хувьд энэ нь эмзэг асуудал бөгөөд орон нутгийн олон суурингуудад ус, эрчим хүчний найдвартай эх үүсвэр байхгүй. Жишээлбэл, Монгол Улсын хүн амын зөвхөн 24 хувь нь төвлөрсөн ундны устай (ДЭМБ/ НҮБХС, 2015).


Уул уурхайн төслийн хайгуулын үе шатанд орон нутгийн оролцоог хангах чиглэлд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажлууд хязгаарлагдмал байна. Гэвч хайгуулын үе шат нь ирээдүйн уул уурхайн төслийн хувьд оролцогч талуудтай харилцаа тогтооход маш чухал үе шат юм. Хайгуулын үе шатанд ирээдүйн төслийн загвар төлөвлөгөөг (жишээ нь: үйл ажиллагаанд шаардлагатай усны эх үүсвэр эсвэл төслийн дэд бүтцийг төлөвлөхдөө усаа хаанаас авах вэ? зэрэг асуултад хариу авах) тооцоолж байдаг. Эдгээр шийдвэрүүд уул уурхайн төслүүдийг тойрон амьдарч буй нутгийн иргэдэд үлэмж хэмжээний эерэг (эсвэл сөрөг) үр дагавартай байж болно. Төслийн техник эдийн засгийн үндэслэл хийх болоход загвар төлөвлөлтийн сонголтыг өөрчлөхөд улам хэцүү болдог учраас аль болох уурхайн мөчлөгийн эрт үед хувилбарт загварын сонголтуудыг хийх нь чухал.

Хайгуулын компаниуд тогтвортой орлогогүй байдаг мөн хөрөнгийн зах зээлийн санхүүжилтээс ихээхэн хамааралтай байдаг зэргийг авч үзээд энэ судалгааны хүрээнд дараах асуултуудыг авч үзэв. Үүнд:

- Эдгээр (хайгуулын) компаниуд орон нутагт үнэ цэнийг бий болгож хуваалцаж чадах уу?
- Эдгээр компаниуд уул уурхайн төслүүдийг сонирхож буй олон оролцогч талуудад үнэ цэнийг хуваарилж чадах уу?

Бритиш Колумбын Их Сургуулийн судлаачдын баг хайгуулын компаниуд ашигт малтмалын ордын ойролцоох орон нутагт үнэ цэнийг бий болгон хуваалцахад оруулах үүрэг оролцоог судлахын тулд Канад Улсад бүртгэлтэй, ашигт малтмалын компани болох Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци ("Эрдэнэ Ресурс")-ийн нарийвчилсан кейс судалгааг (2017 оны 11-р сараас 2018 оны 7-р сар хүртэл) гүйцэтгэсэн. Эрдэнэ Ресурс нь хөрөнгийн биржээр хувьцаагаа арилжаалдаг хувьцаат компани бөгөөд Монголын хөрөнгийн бирж (MSE: ERDN) болон Торонтогийн хөрөнгийн бирж (TSX: ERD)-д давхар бүртгэлтэй.


Эрдэнэ Ресурс нь 20 орчим жилийн турш Монгол Улсад идэвхтэй хайгуулын үйл ажиллагаа эрхэлж байна. Компанийн мэргэжилтнүүд Монголын баруун өмнөд хэсэгт илрүүлсэн ордууд нь Алтан Нар, Баян Хөндий болон Зуун Мод юм. Энэ судалгаанд Эрдэнэ Ресурсийн 100 хувь эзэмшдэг Баян Хөндийн алтны төслийг авч үзэх ба 2018 оны 8-р сарын байдлаар тус төсөл нь хайгуулын ахисан түвшинд байгаа юм. Баян Хөндий нь урьд өмнө нь хайгуулын судалгаа хязгаарлагдмал хийсэн бүсэд газрын дөт гүн дэх өндөр агуулга бүхий алтны орд юм. Эрдэнэ Ресурс нь Баян Хөндийн ордыг уурхайн хөгжүүлэлтийн шатанд шилжүүлэхэд тодорхой эрсдэлүүдийг бууруулах үйл ажиллагаа, алхмыг тодорхойлон ажиллаж байна.



СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны төслийг БКИС-ын Зан үйлийн судалгааны ёс зүйн зөвлөлийн шаардлагуудад нийцүүлэн явуулсан. Ёс зүйн зөвшөөрлийг баталгаажуулахын тулд судалгааны төслийг шинжээчдийн бие даасан хороо үнэлсэн. Судалгаанд ёс зүйн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг үнэлэхдээ судалгааны ёс зүйн үндсэн зарчмуудыг авч үзсэн байна. Үүнд: хүнийг хүндэтгэх, аюулгүй байдал болон шударга ёсыг хүндэтгэх зэрэг багтана.

Судалгаанд холимог аргачлалыг ашигласан (Зураг 1) ба судалгааны үндсэн асуулт нь: Уурхайн мөчлөгийн эхэн үед зэргэлдээ орон нутагт үнэ цэнийг бий болгон хуваалцах боломжтой юу?



Зураг 1 . Төслийн хүрээнд ашигласан холимог аргын ерөнхий тойм.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН СУДАЛГАА

2017 оны 1-р сараас 2018 оны 6-р сар хүртэлх 18 сарын хугацааны компанийн нэр дээрх мэдээний санг мэдээний төлөв, эх сурвалжийн дуу хоолойн¹ эзлэх байр суурийн хувь хэмжээгээр үнэлэх үүднээс авч шинжилсэн. Өгөгдлийг цуглуулахын тулд хоёр төрлийн мэдээ хайлтын системийг ашигласан. Гүүглийн (Google) хайлтын системийг үндсэндээ дотоодод Монгол хэл дээр гарсан нийтлэлүүдийг цуглуулахад ашигласан

бөгөөд “Эрдэнэ Ресурс Девелопмент”; “Эрдэнэ Монгол” болон “Эрдэнэ Ресурс” зэрэг түлхүүр үгүүдээр хайлт хийсэн. Олон улсын хэвлэл мэдээллийг сангаас англи хэл дээр түлхүүр үгүүдийг Фактивиа мэдээ хайлтын системийг ашиглан гүйцэтгэсэн. Factiva нь Dow Jones-д харьяалагддаг бөгөөд 30,000 орчим мэдээний агентлагуудаас контент хүлээн авч агуулдаг.

	Монгол хэл	Олон улсын (англи хэл дээр)
Мэдээ хайлтын систем	Гүүгл /Google/	Факива /Factiva/
Түлхүүр үгс	- Эрдэнэ Ресурс Дэвелопмент - Эрдэнэ Монгол - Эрдэнэ Ресурс	- Erdene Resource Development - Erdene Mongol - Erdene Resource

АЖИГЛАЛТЫН СУДАЛГАА

Энэхүү судалгаанд уул уурхайн салбарын олон улсын болон Монголд зохион байгуулагдсан хурал, цуглаанд оролцож мөн Монголд хийсэн 14 хоногийн судалгааны томилолт зэрэг шууд ажиглалтуудаас цуглуулсан дата дээр хийсэн болно. Ажиглалтаар компанийн орон нутгийн оролцооны арга барил мөн салбарын бусад оролцогчидтой харьцуулан нягтлах боломж бүрдсэн. Ажиглалтын мэдээллийг чанарын ярилцлагын үр дүнг нягтлах мөн дэлгэрүүлэхэд ашигласан.

¹ Дуу хоолойн хувь нь компанийн ажилтнууд шууд иш татсан эсвэл хэвлэл мэдээллийн нийтлэлд хамаарах мэдээлэлтэй байхыг хэлнэ.

Арга хэмжээ	Хугацаа/Газар	Үр дүн
The Mineral Exploration Roundup Conference https://roundup.amebc.ca/	2018 оны 1-р сарын 22-25-ны өдрүүд Ванкувер хот, Бритиш Колумб муж, Канад Улс	- Хоёр ярилцлага хийсэн. - Хайгуул, тогтвортой хөгжил, компанийн нийгмийн хариуцлагын талаарх хурлын илтгэлүүдтэй танилцан, ажиглалт хийсэн.
PDAC https://www.pdac.ca/convention	2018 оны 4-р сарын 4-7 өдрүүд Торонто хот, Онтарио муж, Канад Улс	- Зургаан ярилцлага хийсэн. - Монгол Улсын уул уурхайн өнөөгийн бодлого, гадаадын хөрөнгө оруулалт, уул уурхайн засаглалын байр суурь, чиг хандлагын талаар мэдээлэл авсан. - Салбарын манлайлагчидтай танилцсан. - Салбарын тогтвортой хөгжил, КНХ-ын тэргүүлэх чиглэлийн цаг үеийн мэдээг авсан.
Судалгааны томилолт (Улаанбаатар хот, Баянхонгор аймаг болон Шинэжинст суманд)	2018 оны гуравдугаар сарын 12-24 өдрүүд, Монгол Улс	30 ярилцлага хийсэн. - Томилолтоор улс орон нутгийн нийгэм, байгаль орчин, эдийн засгийн болон ашиг сонирхлын бодит нөхцөлтэй танилцсан.
Усны менежментийн сайн дурын кодекс https://www.commddev.org/south-go-bi-water-and-mining-industry-round-table/	2018 оны гуравдугаар сарын 13-14 өдрүүд Улаанбаатар хот, Монгол Улс	Салбарын жижиг, том, олон улсын болон Монгол уул уурхайн компаниудын төлөөллийн дугуй ширээний үйл ажиллагаанд оролцож ажиглалт хийсэн.
CIM 2018 Convention https://convention.cim.org/	2018 оны тавдугаар сарын 6-9 өдрүүд Ванкувер хот, Бритиш Колумб муж, Канад Улс	- Нийгмийн Зөвшөөрлийн Стратеги дэд хэсгийг зохион байгуулж, даргалан явуулсан бөгөөд тус судалгааны ажлыг танилцуулснаар Эрдэнэ Ресурс компанийн хэрэгжүүлж буй арга барилыг олон нийтэд танилцуулсан. - Судалгааны үр дүнг эхний байдлаар танилцуулж оролцогчдоос ирсэн асуултуудыг дэлгэрүүлэн хэлэлцэж судалгааг нягталсан.
Resources for Future Generation 2018 http://www.rfg2018.org/	2018 оны 6-р сарын 16-21 өдрүүд Ванкувер хот, Бритиш Колумб муж, Канад Улс	- Хурлын панелд оролцож судалгааны ажлаар илтгэл тавьсан. - Хамтын түншлэл хэрхэн тогтвортой хөгжлийн зорилтыг ахиулах боломжтойг Эрдэнэ Ресурс компанийн жишээн дээр танилцуулсан.

Хүснэгт 1. Ажиглалт мэдээллийн эх сурвалж

ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ӨРГӨН ХҮРЭЭНИЙ САНАЛЫГ АВАХ

Судалгааны түүврийг бүрдүүлэхдээ нь харилцан адилгүй төрөл зүйлийн үзэл бодол, туршлага зэргийг хамрах үүднээс дараах хүснэгт дэх төлөөлөл бүхий оролцогчдыг сонгон хамруулсан (Хүснэгт 2).



Хүснэгт 2. Оролцогчдын түүвэрлэлт

Нийт 35 чанарын ярилцлагыг 38 оролцогчидтой² хийсэн бөгөөд нэг бүлгийн ярилцлагыг 5 оролцогчидтой хийсэн. Бүх ярилцлага нь стандарт бус чанарын ярилцлага болон хаалттай асуулга бүхий холимог бүтэцтэй удирдамжийг (Хавсралт А) ашиглан явуулсан.

Канад Улсын Ванкувер, Торонто хотууд, Монгол Улсад Улаанбаатар хот, Баянхонгор аймаг, Шинэжинст сум, Баян Хөндийн төслийн талбай болон Эхийн голын баян бүрд зэрэг байршлуудад ярилцлагуудыг тус тус хийсэн. Бүх ярилцлагыг биечлэн, Англи эсвэл Монгол хэл дээр явуулсан. Нууцлалыг хадгалахын тулд зөвшөөрлийн маягт ашиглан ярилцлагуудад дугаар өгч тодорхойлсон болно.


² 35 ярилцлагын 3-т нь тус бүр 2 хүн оролцсон.

ҮР ДҮН

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

Монгол хэлээр хийсэн мэдээний хайлтаар нийт 49 мэдээний эх үүсвэр дээр 93 нийтлэл илэрсэн. Мэдээний санг мэдээний эерэг, сөрөг болон саармаг төлөвүүдэд ангилахад нийт мэдээний 50 саармаг, 43 эерэг төлөвтэй байсан. Хамгийн өндөр давтамжтай мэдээний үе нь 2018 оны 5 болон 6-р сард бүртгэгдсэн бөгөөд (66/93) энэ нь тус компани Монголын хөрөнгийн биржид хувьцаагаа бүртгүүлэн арилжаалах болсон арга хэмжээтэй уялдаж байгаа юм.

Фактива мэдээний хайлтын системээр нийт 63 нийтлэл 2017 оны 1-р сар болон 2018 оны 7-р сар хоорондын хугацаанд илэрсэн. Олон улсын хэвлэл мэдээлэлд нийтлэгдсэн эдгээр мэдээнүүд голчлон тус төслийн өрөмдлөгийн үр дүнгийн мэдээ байгаа юм. Монголын хөрөнгийн биржид хувьцаа бүртгэгдсэн талаарх мэдээ 2 байхад, Баян Хөндий төслийн мэдээ 47 буюу хамгийн ихээр мэдээлэгдсэн, мөн Алтан Нарын тухай 37 мэдээ илэрсэн. Фактивагаар илэрсэн бүх нийтлэлүүд саармаг төлөвтэй байсан.



Зураг 2 – 2017 оны 1-р сар - 2018 оны 6-р сарын хооронд Эрдэнэ Ресурс компанийн талаар гарсан мэдээний илэрц

КОДЛОХ (CODING)

Хэвлэл мэдээллийн судалгаа баримт бичгийн судалгааг ангилахдаа түлхүүр үгсийг ашиглан ангилсан (Хүснэгт 3). Хийгдсэн ярилцлагуудыг хөврүүлэн авч анализ хийхдээ тус түлхүүр үгс буюу урьдчилан боловсруулсан кодуудыг ашигласан.

Судалгааны кодлох ангилал					
Хүлээлт	Итгэл	Итгэл хүлээсэн	Харилцаа холбоо	Оролцоог хангах	Боломжууд
Ашиг шим	Нөлөөлөл	Нийтлэг үнэ цэнийг бий болгох	Ус	Хайгуулын ажил	Нэр хүнд

Хүснэгт 3. Өгөгдлийн шинжилгээнд зориулан боловсруулсан түлхүүр үгс эсвэл кодууд

СЭДЭВЧЛЭЛ

Ярилцлагуудыг хөврүүлж гаргаж авсан дата дээр NVivo програмыг (QSR 2018) ашиглан баримтын уялдаа холбоо, шүтэлцээ үндэслэл зэргийг бусад дээр дурдсан аргаар гарч ирсэн баримт нотолгоотой нягтлан шинжилсэн. Ярилцлагын баримт дээр хийсэн дүн шинжилгээгээр уялдаа холбоо бүхий таван сэдэв гарч ирсэн (хүснэгт 4). Сэдэв тус бүр дээр гарч ирсэн агуулгуудыг Хүснэгт 4-ийн сэдэв тус бүр доор жагсаасан болно.

Эдийн засгийн хөгжил	Мал сүрэг	Байгаль орчин	Ус	Засаглал
- Ажил эрхлэлт - Боломжууд - Орон нутгийн худалдан авалт - Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд - Нэмэгдсэн өртөг шингэсэн - МХБ-д бүртгэгдсэн	- Мал сүргийн эрүүл мэнд доройтох - Тоосжилт/Уур амьсгалын өөрчлөлт/Ган/Зуд - Бэлчээр, усны зөрчлүүд	- Цаг агаарын өөрчлөлт - Агаарын чанар - Хүнд өвөлжилт/Ган гачиг - Бэлчээр багасах - Хөрсний элэгдэл - Замын нөлөөлөл - Бичил уурхай	- Хүртээмж - Чанар - Шинжилгээнд өгөх болон хяналт тавих шаардлага - Усны ашиглалтын гадаргын болон гүний нөөцөд үзүүлэх нөлөө	- Чадавхи - Авилга - Бодлогын тодорхой бус байдал - Итгэлцэл сул - Ил тод байдал дутмаг

Хүснэгт 4. Судалгааны гол болон харилцан хамааралтай сэдвүүд

АСУУДЛУУД

Ярилцлагад оролцогчийн компани эсвэл орон нутагт тулгарч буй хамгийн чухал асуудлуудыг тодруулахыг хүсэхэд доорх дөрвөн сэдэв хамгийн их хөндөгдсөн (Хүснэгт 5):

1. Ашигт малтмалын салбарын сөрөг нэр хүнд;
2. Салбарын засаглалтай холбоотой бэрхшээлүүд;
3. Говийн бүсийн усны хүртээмж;
4. Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаарх түгшүүр.

Эдгээрээс хэд хэдэн асуудал нь хоорондоо уялдаа холбоотой, тухайлбал ус ба байгаль орчны асуудлууд юм. Дээрх асуудлуудыг Компанийн төлөөлөгчид болон оролцогч талууд аль аль нь чухалчлан авч үзэж байгаа бөгөөд Компанийн анхаарал хандуулж буй асуудлуудын нэг юм.

Хэдийгээр уул уурхай сөрөг нэр хүндтэй гэгдэж байгаа ч ярилцлагад оролцогчдын нэг нь ийнхүү хэлсэн байна:

“Уул уурхай нь өнөөгийн эдийн засгийн салшгүй, чухал хэсгийн нэг бөгөөд үүнийг орхиж боломгүй, цааш үргэлжлүүлэх хэсэг гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа, магадгүй зарим нэг нь дуртай дургүй зөвшөөрч байгаа нь байдаг. Нөгөөтээгүүр Монголчууд гаднынханаар ашигт малтмалаа олборлуулснаар өөрсдийн хувь заяаны удирдлагаа алдаж байгаа юм шиг мэдрэгддэг байх гэж бодогддог.”

Уул уурхайн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар оролцогчид нэлээд хөндсөн байна. Зарим нөлөөлөл нь бэлчээрийн талхидал, уур амьсгалын өөрчлөлт гэх мэт бусад хүчин зүйлсээс хамаарч байж болох юм. Гэсэн хэдий ч салбарын үйл ажиллагаа ил явагддагаас тоосжилт, экосистем алдагдах, цөлжилт, усны хомстол гэх мэт байгаль орчны сөрөг нөлөөллийн буруутан гэж үзэх хандлагатай байдаг. Жишээ нь, нэг ярилцагч:

“Бэлчээрийн газар улам бага болсоор байна. Ашигт малтмалын хайгуулын төслүүдээс болон бид бэлчээрээ алдаж байна гэж боддог.”

Үүнээс гадна байгалийн баялгийг гаднын өмчлөлд байгаад санаа зовниж байгаа тодорхой зарим асуудал байна. Гадаадын компаниуд үл сэргээгдэх нөөцийг ашиглаж дуусаад орон нутаг, нийгэм, байгаль орчинд эвдрэл гэмтэл үлдээгээд орхиод гарна гэж хэсэг оролцогчид үзэж байна.

Орон нутгийн оролцогч талуудын үзэл санаа бодит нөхцөл мэт байдлыг бий болгодог. Тиймээс ч оролцоог хангах сайн стратеги бүхий компаниудын хувьд “шинжлэх ухааны эсвэл нотолгооны үндэслэлд тулгуурласан эсвэл зөрчил үүсгэх магадлалтай” эсэхээс үл хамааран оролцогч талуудын үзэл бодлыг чухалчлан авч үздэг. Сайн стратеги нь компаниудыг оролцогч талуудын үзэл санаа, ойлголтыг чухалчлан авч үзэж шийдвэрлэхийн тулд бодит арга хэмжээ (төслийн аль мөчлөгт байгаа болон боломжит нөөц хэмжээнээс хамааран) авахыг хэлнэ.

5-р хүснэгтэд Асуудлыг тодорхойлох өгөгдлөөс үүсэх нийтлэг үндэслэлийн цэгүүдийг харуулав.

Оролцогч талуудын бүлгүүд	Салбар (2)	Хөрөнгө оруулагч (1)	Нөлөө бүхий төлөөлөл (5)	Орон нутгийн засаг захиргаа (4)	Орон нутаг (4)	Малчид (3)	ИНБ / ТББ (6)	Компанийн ажилчид (7)	Компанийн удирдах зөвлөл (3)
Асуудлууд (дараалал дурдагдсан # -т суурилсан)									
Салбарын сөрөг нэр хүнд (13)	2		3		1		3	4	
Салбарын засаглал (12)	1		2				3	4	2
Өмнийн говийн ус (11)				1	4	2	1	2	1
Байгаль орчин (10)			3	3	1	3	3		
Бэлчээр (7)			1	2	1	3			
Мал сүрэг(6)			2	2	2	2			1
Хөдөлмөр эрхлэлт / эдийн засгийн хөгжил (6)				2	2		2		
Хөрөнгийн эх үүсвэр (5)		1					1	3	
Итгэл (4)							1	2	1
Хүлээлтийг хянах (4)	1		1					2	
Ил тод байдал (3)	1						2		
Соёлын өөрчлөлт (3)							2	1	
Бусад * (1)									

Хүснэгт 5. Ярилцлагын удирдамжид Асуулт №1-т оролцогчид хамгийн их хөндсөн асуудлууд юм. Холбогдох асуудлуудаас шалтгаалан дурдсан тоо нь оролцогч талуудын бүлгүүдийн тооноос илүү байж болно.* Бусад сэдвүүдэд цахилгаан эрчим хүчний хомстол, “нинжа” уурхайчид, бага орлого, салбарт оролцоог хангах дутмаг байдал (1 тус бүр) зэрэг байгаль орчинтой холбоотой асуудлууд орно.

УУЛ УУРХАЙН НЭР ХҮНД

“Нэгдүгээрт, манайд олон нийтэд сөрөг жишиг ба буруу ойлголтыг тархаасан бичил уул уурхай, нинжанууд бий.”

“Уул уурхайн талаар миний мэддэг ганцхан зүйл бол тэд байгалийн баялагийг нь ухааж аваад л хаячихдаг.”

“Олон компаниуд хууль бус, хямд төсөр байгаль орчинд хор нөлөөтэй арга барилаар үйл ажиллагаагаа явуулдаг.”

“Эдгээр үндэстэн дамнасан корпорацууд болон тэдний бүх салбар оффисууд нь нэг маягаар ажилладаг гэж бодохгүй байна.”

“Муу компаниуд нь Монголын жижиг компаниуд буюу ялангуяа алтны салбарынхан байна. Тэд зүгээр л ашигладаг. Тэд албан ёсных ч байсан, биш ч байсан байгаль орчны стандартыг огт хайхардаггүй.”

“Жижиг, хариуцлагагүй компаниудын улмаас орон нутаг тэр чигээрээ уул уурхайн эсрэг байсан. Ганцхан муу байхад л хангалттай.”

ЭРДЭНЭ РЕСУРСИЙН ТАЛААРХ СЭТГЭГДЭЛ

Ярилцлагад оролцогчдын тодорхой хэсэг Эрдэнэ Ресурстай холбоотой асуулгад хариулж, Монголд үйл ажиллагаа явуулж буй бусад компаниудтай Эрдэнэ Ресурсийг харьцуулалт хийсэн.

Оролцогч талуудын бүлэг	# оролцогч
ИНБ / ТББ	9
Салбар	1
Орон нутаг	4
Нөлөө бүхий төлөөлөл	2
Хөрөнгө оруулагчид	1

Хүснэгт 6: Зориудаар сонгосон тоон ярилцлагын дээж

Асуулга авсан дэд түүвэр компанийн талаар маш эерэг сэтгэгдэлтэй байсан. Жишээ нь:

"Би тэдний тухай мэддэг болоод удаж байна. Тэдний орон нутгийн асуудалд хандах хандлага нь эзэрхэг биш, энэ нь үнэхээр нээлттэй зүйл гэж би боддог. Миний харилцдаг, орон нутгийн асуудалд үүрэг хариуцлага бүхий хүмүүс ажлаа сайн хийх гэдэг зарчим дээр хатуу зогсдог. Энэ нь аливаа асуудал дээр илүү хамтарч хийдэг гэж болно."

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх иргэдийн (92%) нь Эрдэнэ Ресурс компанийн талаар эерэг сэтгэгдэлтэй байсан. Зарим оролцогчид бүх асуултад хариулах хангалттай мэдээлэл байхгүй гэж үзэж байсан ч компанийн талаар сөрөг сэтгэгдэл байхгүй байна. Бүх асуулгад 90% ба түүнээс дээш хувь нь доорх хариулт дээр нэгдсэн:

- Эрдэнэ Ресурс нь бусад хайгуулын компаниудаас илүү сайн;
- Эрдэнэ Ресурс нь байгаль орчинд ээлтэй байдлаар ажилладаг;
- Эрдэнэ Ресурс нь орон нутагтай үр дүнтэй харилцдаг;
- Эрдэнэ Ресурсын төслийг итгэж болох хүмүүс удирддаг;
- Компани нь орон нутгийн асуудалд анхаардаг;
- Эрдэнэ Ресурс уурхай болгон өргөжүүлэх ордыг нээн илрүүлбэл орон нутагт үр ашигтай.

Эдгээр эерэг сэтгэгдлүүдийг үл харгалзан орон нутгийн оролцогч талуудаас зарим санаа зовоосон асуудлуудыг хөндсөн гэдгийг дурдах нь чухал юм.

ЭРДЭНЭ

"Эрдэнийх бусад хайгуулын лиценз эзэмшигчийг бодвол сум орон нутагтайгаа ойрхон ажилладаг. Тэднийх сум аймагтаа үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн сайн компаниудын нэг гэж хэлж болно."

"Би энэ компанийг ирээдүйн төслүүдэд хамтран ажиллах боломжтой компани гэдэгт итгэж байна. Би тэднийхтэй цаашдын төсөл хөтөлбөрт хамтарч ажиллахад итгэж болох компани гэж үздэг."

"Тэд сайн муу аль ч үед Монголыг орхиогүй. Тэд зөвхөн өөрсдийн зорилгодоо хүрэхийн тулд Монголыг мэддэг болох гэж хичээдэггүй. Тэд хамтын ажиллагаа, бизнесийн соёл, нийгмийн нэг хэсэг нь болчихсон. Тэдний ялгардаг шинж нь олон төрлийн санал бодолд нээлттэй байдаг."

"Би Эрдэнэ Ресурсийг зөв зүйл хийхийг хүсдэг тэгээд энэ үе шатанд түүндээ төвлөрөн хийгээд явж байгаа гэсэн сэтгэгдэлтэй байдаг."

"Орон нутагт хувь нэмэр оруулж, тусламж дэмжлэг, тэтгэлэг олгодог. Тэд сургуулийн спортын уралдаан тэмцээний шагналыг санхүүжүүлдэг."

АСУУДЛУУД

“Өнгөрсөн жилүүдийн муу туршлага хүмүүсийн толгойд үлдэн, уул уурхай муу гэсэн ойлголтыг бий болгосон, энийг л малчид толгойноосоо гаргаж авч хаяхгүй байгаа хэрэг.”

“Би гомдол санал ирэх болгонд албан тоот бичиж компанийн удирдлагад хүргүүлдэг. Мөн шууд залгаж ирсэн гомдол саналын талаар хэлэхэд Компани тэдгээр малчин өрхтэй уулзана гэдгээ хэлдэг.”

ОНЦЛОХ АСУУДЛУУД

Аливаа хайгуул, олборлолтын төслийн хувьд орон нутгийн оролцогч талуудын хувьд уул уурхайн үйл ажиллагаа явуулах тал дээр өөр өөр үзэл бодолтой байхаас гадна амьдарч буй нутаг орондоо уурхайг байлгах тал дээр нэгдсэн зөвшилцөл байхгүй байх нь ердийн үзэгдэл юм. Эрдэнэ Ресурс болон Баян Хөндий төслийн талаар аймаг, сумын хэмжээнд орон нутгийн цөөн оролцогч талуудын цөөн хэсэг нь зарим асуудлуудыг тавьсан. Эдгээр асуудлуудыг Хүснэгт 7-д нэгтгэн харуулав. Улаанбаатар хот эсвэл Канад улсад хийсэн ярилцлагын үеэр компанид тухайлан хандсан асуудлууд гаргаж тавиагүй болно.

Сумын түвшинд Шинэжинст болон Баян-Өндөрт ажиллаж буй төрийн албан хаагчид тэдгээр асуудлуудыг Эрдэнэ Ресурсын анхааралд хэрхэн хүргэхээ мэддэг. Энэ өргөдөл, гомдол барагдуулах, тодорхой асуудлыг компанийн анхааралд хүргэх, хэрхэн мэдээлэх мэдлэг нь төслийг орон нутгийн дэмжлэгтэйгээр урагшлуулахад чухал ач холбогдолтой.

Эрдэнэ Ресурсаас гадна хайгуул болон олборлолт хийж буй компаниуд тус бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Эрдэнэ Ресурс харилцааны нээлттэй сувгийг бий болгосноор орон нутгийн иргэд бусад компаниудын үйл ажиллагааны талаар санал гомдлыг Эрдэнэ Ресурс хандаж мэдээлсэн тохиолдлууд ажиглагдсан.

Орон нутгийн иргэд, оролцогч талуудын хайгуул болон уул уурхайн үйл ажиллагааны талаарх ойлголт нь компанийн ажилтнуудын шинжлэх ухааны тооцооллоос зөрүүтэй, эсрэг тэсрэг байх нь бий. Оролцогч талуудын үзэл бодол нь тэдний бодит нөхцөл байдал, зүй ёсны анхаарал, тооцооллоор бүрддэг гэдгийг анхаарах нь чухал.

Сэдэв	Тавигдсан асуудлууд
Усны хомсдол	Өмнө говийн зарим оролцогч тал бүс нутгийн ус газар доогуур холбоотой бөгөөд хайгуулын эсвэл олборлолтын зориулалтаар нэг худгаас ус хэрэглэхэд малчид хэрэглэдэг бусад худгийн ус багасна гэсэн ойлголттой байна.
Усны чанар	Зарим хүмүүс усны өнгө шохойлог болж, мал өвдөж байгаа нь усны чанар муудсантай холбоотой гэсэн асуудал тавьсан. Цаашид усны чанарын жишиг тогтооход усанд шинжилгээ хийх хэрэгтэй.
Тоосжилт / зам	Хайгуул, олборлолтод ашигладаг томоохон ачааны болон өрмийн машин тоосжилтыг бий болгож байгаа нь мал сүргийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй. Олборлолт болон хайгуулын компаниуд тоосжилтыг дарах хангалттай арга хэмжээ авахгүй байна гэсэн шүүмжлэл байна.
Хайгуулын лиценз болон зөвшөөрөлтэй бүсээс гадуур ажиллах	Зарим хайгуул, олборлолтын компаниуд нь зөвшөөрөлтэй талбайгаас гадуур үйл ажиллагаа явуулснаар байгаль орчин сүйтгэж мөн малчдын худгийн уснаас хороож байна гэсэн асуудлууд дурдагдсан.
Бэлчээрийн элэгдэл / цөлжилт / хөрсний доройтол / ургамалд үзүүлсэн хохирол	Хайгуул, олборлолтын компаниудын ухсан нүх нь мал бэртэж эндэх аюултай, говийн хөрсөнд шинээр гаргасан зам бэлчээр доройтуулж, ургамал төрлийг устгаж байгаас гадна нөхөн сэргээлт гүйцэд хийхгүй байгаа гэх мэт асуудлууд тавигдсан.
Компанийн нэр гуйвуулан ашиглах	Хариуцлагатай уул уурхай эрхэлдэг гэсэн нэр хүнд бүхий компаниудын нэрийг хариуцлагагүй үйл ажиллагаа эрхэлдэг иргэд, аж ахуйн нэгж гуйвуулан ашигладаг тохиолдол байна. Энэ нь эерэг нэр хүнд бүхий компанийн талаарх ойлголтод сөргөөр нөлөөлдөг байна.

Хүснэгт 7: Шинэжинст, Баян-Өндөр сумдад хийсэн ярилцлагын явцад гарсан орон нутгийн тулгамдсан асуудлууд.

ОРОН НУТГИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ НЬ

Бүх оролцогчдоос хайгуулын компаниуд ашигт малтмалын хайгуул хийгдэж байгаа газарт ойр байгаа орон нутагтай ямар харилцаатай байх ёстой талаар асуусан. Олон оролцогчид Эрдэнэ Ресурс нь дор хураангуйлсан сайн дадал туршлагыг хэрэгжүүлж байгааг сайшаасан. Жишээ нь, компанийн тэтгэлэгт хөтөлбөр нь олонд танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн, мөн ярилцлагад оролцогчдын 30% нь энэ хөтөлбөрийг орон нутагт оруулж байгаа эерэг хөрөнгө оруулалтын жишээ гэж үзсэн. Судалгаанд оролцогчдын тодорхойлсон компани – орон нутаг хоорондын эерэг харилцааны ерөнхий шинж чанаруудыг доорх 4 ангилалд хувааж, ярилцлагаас татсан ишлэлтэй танилцуулж байна.

АЛСЫН ХАРАА

- Орон нутгийн нөхцөл байдлыг ойлгох

“Хэрэгцээ нь орон нутаг тус бүр харилцан ялгаатай. Миний бодлоор тухайн орон нутгийн хэрэгцээг тодорхойлж, тэрэнд нь боломжоороо тусалцаа хүргэх нь маш чухал.”

- Компанийн мэдээ мэдээллийг хөрөнгийн зах зээлээс хөршийн түвшинд нэгтгэх

“Хайгуулын төслийн үнэ цэнийг нуун далдалж байгаа гэж хүмүүс бодож байгаа үед орон нутагт үл итгэх байдал үүсдэг. Хайгуулын компаниуд ‘Энэ төсөл нь сая сая долларын өртөгтэй байх магадлалтай’ – гэх зэргийн маш сайн мэдээг хөрөнгө оруулагчдад дуулгахыг хүсч байдаг. Тийм боловч, орон нутагт бидэнд одоогоор юу ч байхгүй учир юу ч амлаж чадахгүй гэнэ. Хүмүүс тэнэг биш. Тэд мэдээлэл авах чадвартай, мэдээллүүд нь хоорондоо таарахгүй байх нь үл итгэлцэл үүсгэдэг.”

СТРАТЕГИ

- Төлөвлөсөн, системчилсэн оролцоог хангах ажиллагааг эрт эхлэх, ингэснээр хүмүүст төсөл болон холбогдох өөрчлөлтүүдэд бэлтгэх, ойлгох хугацаа өгөх

“Гол нь тэднийг хамтран ажиллах хөтөлбөрөө эхлэхээс өмнө төлөвлөсөн байх, мөн ямар мэдээг хэрхэн өөр өөр түвшинд хэрхэн хүргэхийг хүсч байгаагаа мэдэж байх нь чухал гэж бодож байна. Энэ нь [компаниуд] олон улсын зах зээл дээр болон төслийн талбайн ойр орчимд байгаа хөршүүддээ хүргэх мэдээллийг нэгтгэх хэрэгтэй. Компанийн гаргаж байгаа мэдээнүүд нь өөр өөр түвшинд хүргэж болох стратегийг сайтар мэддэг байх хэрэгтэй.”

- Нээлттэй, үнэнч шударгаар харилцах, ил тод байдлыг хангах

“Шийдвэрлэхэд хэцүү эсвэл компани шийдвэрлэх боломжгүй олон асуудлууд байж болох ч бүх нөхцөл ил тод байдал чухал юм. Хэн нэгэн сүрдүүлэх байдал гарах магадлалтай бөгөөд ил тод байдал нь чухал. Ирж байгаа санал хүсэлтийг хүлээн авах компанийн сувагтай бол үйл ажиллагаатай холбогдолгүй эсвэл нөлөө бүхий хүмүүсээс ирэх түрэмгий хүсэлтүүдийг багасгахад тустай. Мөн худалдан авалтын ажиллагаа бүрэн ил тод, түнш сонгон шалгаруулалтын үйл явц нь тодорхой бол танил тал ашигласан, арын хаалгаар гэрээ хэлцэл хийх боломжгүй.”

ХАРИЛЦАА ХОЛБОО

- Урт хугацааны харилцааг бий болгох. Бүх оролцогч талуудыг авч үзэн, үйл ажиллагаа удаан, зогсонги байх үед ч байнгын харилцаатай байх

ЭРДЭНЭ РЕСУРС ОРОН НУТГИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ БАЙДАЛ

“Эрдэнэ орон нутгийн хөгжилд чухал дэм дэмжлэг болдог. Компани боловсрол, тэтгэлэг, эрүүл мэнд зэрэг олон төсөл хөтөлбөрт тодорхой төсөв төлөвлөдөг.”

“Тэднийх орон нутгийн засаг захиргаанд ямар хүндрэл бэрхшээл байгааг, юунд тусламж хэрэгтэй байгааг мэддэг.”

“Манай суманд олон хайгуулын тусгай зөвшөөрөл байдаг ч Эрдэнэс өөр компани орон нутагт хувь нэмэр болж тусламж үзүүлдэггүй.”

“Баян-Өндөр, Шинэжинст хоёрт худаг гаргасан. Дээр нь орон нутгийн хүүхдүүдэд тэтгэлэг өгдөг. Мөн бусад жижиг төслүүдийг зуунмод, эхийн гол аймгийн төвд хэрэгжүүлээд байдаг. Тийм болохоор би энэ компани ажилдаа хариуцлагатай гэж итгэдэг. Тэд аймгийн Мазаалай Паркийг байгуулахад хувь нэмэр оруулсан.”

“Зарим хамтын ажиллагаа, гэрээ хэлцэл нь сургалт, боловсролын чиглэлтэй байж болно. Гэхдээ миний хувьд эхлээд сонсож, дараа нь хамтран ажиллах түншлэлийг бий болгох хэрэгтэй”.

“Компанийн төвлөрөх хэрэгтэй зүйл нь аль болох эрт харилцааг үүсгэж, байнга анхаарах юм. Энэ нь магадгүй хэт улиг болсон эсвэл ерөнхий сонсогдож магад. Гэхдээ сонсох гэдэг нь үндсэн ажил юм. Ярих биш, харин сонсох хэрэгтэй.”

“Эрдэнэ Ресурс аймгийн төдийгүй улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Уул уурхайн үндэсний ассоциацтай хамтран Discover Mongolia арга хэмжээг зохион байгуулсан. Тэгэхээр зөвхөн орон нутагт ч гэлтгүй, харин үндэсний түвшинд ч идэвхтэй байх хэрэгтэй.”

ИРГЭД

- Хайгуулын болон уул уурхайн төслүүдийн үр ашгийг цөөн тооны элитүүдэд бус, бүх иргэдэд хүртээх боломжийг бүрдүүлэх нь чухал юм. Амжилттай хөтөлбөр, харилцааг бий болгоход орон нутгийн оролцоог хариуцсан компанийн ажилтнуудад дэмжлэг үзүүлэх

“Орон нутгийн иргэд шийдвэр гаргалт, хэлэлцүүлгийг ганцаарчилсан уулзалтаар бус, бүлгийн хүрээнд хийгддэг гэдгийг мэдэж ойлгох нь чухал юм.”

“Хэрэв орон нутгийн иргэд оролцох боломжтой байгаа бол азтай байна. Ихэвчлэн засаг дарга эсвэл түүнд ойр хэсэг бүлэг хүмүүс оролцдог. Хээл хахууль, мөнгө авч, гарын үсэг зурдаг нь уламжлал болсон. Уул уурхайн компаниуд гол төлөв засаг дарга болон түүний найз нөхөд юу хүссэн, түүнийг нь хэрхэн авч өгч байж гарын үсэг авсан талаар ярьдаг. Тэгэхээр орон нутаг, иргэд өөрсдөө “Бид энийг, тэрийг авч болох уу” гээд санал өгөх, оролцох тохиолдол байгаа нь сайн уламжлал тогтож буйг илэрхийлж байна.”

“Эрдэнэ Ресурсад тэдний төлөө ажиллаж байдаг, мэдлэгтэй мэргэжилтнүүд байдаг. Ихэнх хайгуулын компаниудад нийгэм, байгаль орчинд зориулсан нөөц байдаггүй.”

ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ - ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТҮНШЛЭЛ

Мэдээллийн шинжилгээний хэсэг болгон оролцогч талуудын ашиг сонирхол/асуудлыг таван сэдэвт (Хүснэгт 4-т тайлбарласан) оруулсан дүгнэлтийг НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай (ТХЗ) зэрэгцүүлэн боловсруулсан. 2015 оны 9-р сард дэлхийд хамгийн их тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх төлөвлөгөөг тусгасан нийт 17 тогтвортой хөгжлийн зорилтууд батлагдсан.

Монгол Улсыг оролцуулан 190 гаруй улсын засгийн газрууд эдгээр зорилтуудад³ нэгдсэн байдаг. Үүнээс гадна Монгол Улсын засгийн газар 2030 он хүртэлх өөрийн үндэсний тогтвортой хөгжлийн алсын харааг боловсруулсан (Монгол Улсын Засгийн газар, 2016 он). Баянхонгор аймгийн Баян-Өндөр болон Шинэжинст сумд үндэсний болон орон нутгийн бодлогын зорилтуудын хэрэгжилтийг дэмжих бүс нутгийн хөгжилд чиглэсэн орон нутгийн түвшний тогтвортой хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж байна.

Ярилцлагын үр дүнгээс харахад орон нутгийн удирдлагууд уул уурхайг эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлт, байгалийн нөөцийн удирдлагыг сайжруулах хөдөлгүүр гэж үзэж байна. Мал аж ахуй нь орон нутгийн иргэдийн амьжиргааны үндсэн эх үүсвэр учир уул уурхайг эрхлэхдээ мал аж ахуйд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах нь чухал гэсэн байр сууриа тодотгож байсан.

Орон нутгийн тулгамдсан асуудлууд болон боломжуудыг ТХЗ-уудад уяснаар Эрдэнэ Ресурсийн орон нутагт оруулж буй хувь нэмрийг дэлхийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд харах боломжтой юм. Судалгааны үр дүнг зургаан ТХЗ-тод буулгалаа (4, 6, 7, 9, 13, ба 17-г доорхи 3-р зурагт үзүүлэв). Зарим ажлууд нь Эрдэнэ Ресурсийн эрүүл мэнд, боловсрол, усны чиглэлээр хийж байгаа ажлуудтай нягт уялдаж байна. Бусад нь (тухайлбал, ТХЗ-ууд 7, 9, 13, 17) ирээдүйн уурхайн талбайд сэргээгдэх эрчим хүчийг нэгтгэн ашиглах боломжийг судалж, үнэлж буй компанийн одоогийн ажилд хамаарна. Энэ шинжилгээ нь засгийн газар, нутгийн тэргүүлэх чиглэлүүд болон компанийн ашиг сонирхлууд давхцаж буйг тодорхой илтгэж байгаа бөгөөд эдгээр чиглэлүүдэд цаашид хамтран ажиллах боломжтой.



Зураг 3 – Эрдэнэ Ресурс болон орон нутгийн тэргүүлэх чиглэлүүд ТХЗ-уудтай давхцаж буй нь.

³ (<https://www.un.org/sustainabledevelopment/sustainable-development-goal>)

ҮНЭ ЦЭНИЙГ БИЙ БОЛГОЖ, ХУВААЛЦАХ

Судалгаа нь хайгуулын компаниуд хөрш зэргэлдээ орон нутагтаа үнэ цэнийг бий болгож хуваалцах арга замуудыг гаргаж ирэх зорилготой. “Нийтлэг үнэ цэнийг бий болгож хуваалцах” гэдэг нь макро эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэн, бизнес болон нийгэмд аль алинд нь ашигтай үр дүнд хүрэх бизнес, нийгмийн огтлолцлын цэгийг олох эдийн засгийн стратеги гэж тодорхойлсон байдаг (Портер & Крамер, 2011). “Нийтлэг үнэ цэнийг бий болгох” гэдэг нь оролцогч талуудын хувьд өөр өөр ойлголтыг илэрхийлнэ. Гэсэн хэдий ч ярилцлагаар оролцогчид энэ агуулгыг тодорхойлохдоо энэ нь нийтлэг ашиг сонирхол гэдгийг хэлж байсан бөгөөд энэ нь Монголын уул уурхайн салбарт чухал хамааралтай юм.

“Уурхай барих нь зөвхөн компанийн асуудал биш юм. Үүнд орон нутгийн засаг захиргаа мөн хамаарна. Байгалийн баялаг хүн бүрийнх учир хүн бүр үнэ цэнэ хүртэх ёстой.”

Судалгаанд оролцогчдоос нэг оролцогч “жижиг компаниуд [нийтлэг үнэ цэнийг бий болгож] чадахгүй” гэж үзэж байсан хэдий ч энэ судалгаа Эрдэнэ Ресурс нь амжилттайгаар нийтлэг үнэ цэнийг бий болгож хуваалцсан гэж дүгнэж байна. Нийтлэг үнэ цэнэ бүтээсэн тодорхой ажлуудаас дурдвал:

- Сумын сургууль төгсөгчдөд зориулсан тэтгэлэгт хөтөлбөр,
- Усны санаачилгууд:
 - Малчдад зориулсан худаг гаргасан.
 - Шинэжинст сумын төвд анхны ундны усны эх үүсвэрийг тогтоож, худаг гаргасан.
 - Малчдын эвдэрсэн худгуудыг засаж сайжруулсан.

Судалгаагаар гарч ирсэн компани – орон нутаг хоорондын хамтран ажиллах боломжтой чиглэлүүд нь ТХЗ-уудтай нийцэж байна. НҮБ-ын ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд бизнесийн стратеги нэн чухал бөгөөд нийтлэг үнэ цэнийг бүтээх, хуваалцах энэхүү онол практикийн арга барилыг компаниуд стратеги болгон ашиглах боломжтой юм. Цаашилбал, хамтын түншлэлийг бий болгох нь нийтлэг үнэ цэнийг бий болгох гол түлхүүр бөгөөд засгийн газар үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшний тогтвортой хөгжлийн төлөвлөгөөнд заасан бодлогын гол зорилтуудад хүрэхэд уул уурхайн компаниуд дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлж байна. Компаниуд оролцогч талуудын оролцоог хангах ажиллагаагаа ТХЗ-уудтай уялдуулснаар нь орон нутгийн бодлогын зорилтууд болон дэлхийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд төслүүдээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд ач холбогдолтой.

“Хэрэв Эрдэнэ Ресурс хүсвэл тогтвортой хөгжлийн стратегийг ТХЗ-уудад уялдуулан холбосон, Монголд үйл ажиллагаа явуулж буй анхны компани болж болох юм.”

ХАМТЫН ҮНЭ ЦЭНИЙГ БИЙ БОЛГОХ

“Аливаа уурхайг хөгжүүлэх нь уурхайг бий болгоход хөрөнгө оруулсан компанид төдийгүй орон нутагт үр ашигтай байх гэсэн үг юм.”

“Миний хувьд нийтлэг үнэ цэнийг хуваалцах нь оролцогч талууд бүгд үр ашгийг хамгийн өндөр түвшинд хүртэх гэсэн үг юм.”

“Магадгүй нийтлэг үнэ цэнийг бий болгох боломж гэдэг нь орон нутаг болон компанийн ашиг сонирхлыг нэгтгэхийг хэлнэ.”

“Миний хувьд энэ нь бизнесийн үнэ цэнийг хадгалж үлдэх, төслөө хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид, удирдах зөвлөл болон ажилтнууддаа ашиг орлого олж өгөх, мөн тухайн орон нутагт эерэг нөлөө үзүүлэхийг хэлнэ.”

“Монголд яагаад нийгмийн хэмжээнд уул уурхайн талаар сөрөг ойлголттой байна вэ гэвэл өнгөрсөн хугацаанд бид нийтлэг үнэ цэнийг бий болгоогүйд байгаа юм. Зөвхөн төсөл, уул уурхайгаас ашиг олсон компаниуд л байна.”

“Нийтлэг үнэ цэнэ гэдэг нь орон нутаг ашигт малтмалын олборлолтоос үүсэх эрсдэл буюу ашигт оролцоотой байх гэж би боддог.”

Уул уурхай ба орон нутгийн тогтвортой хөгжил			
ТХЗ-ууд	Орон нутгийн ярилцлага: Аймаг, сум, малчид	Компанийн ярилцлага: Ажилтнууд, удирдлага, ТУЗ	Нийтлэг ашиг сонирхол
	Гол асуудал	Гол асуудал	
6: Баталгаат ундны ус & ариун цэврийн байгууламжаар хангах 9: Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	Ус	Ус	- Усны хэмжээ - Ус чанар/шинжилгээ - Усны сав газраас ус татахад үзүүлэх нөлөө - Ундны усны хүртээмж - Усны худаг өрөмдөх-арчлах
15: Хуурай газрын эко системийг хамгаалах	Байгаль орчны хамгаалал	Байгаль орчны менежмент	- Хөрсний элэгдэл/цөлжилтийг бууруулах - Хайгуул/уурхайн талбайг нөхөн сэргээх - Уур амьсгалын өөрчлөлтийн (хүнд өвөл, хөрсний элэгдэл, ган гачиг, хур тунадас бууралт) нөлөөллийн талаар арга хэмжээ авч ажиллах - Бэлчээрийн олдоц/чанар
1: Ядуурлыг бууруулах	Ажил эрхлэлт	Орон нутгийн иргэдийг сургах, ажилд авах	- Орон нутагт ажиллах боломжууд - Орон нутгийн боловсролтой боловч ажилгүй байгаа залуучуудад боломж олгох
8: Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох	Эдийн засгийн хөгжил	Орон нутгийн худалдан авалт, хөрөнгө оруулалт	- Ноолуур боловсруулалт хөгжүүлэх - ЖДҮ эрхлэгчид хайгуул ба олборлолтын ажиллагаанд ханган нийлүүлэлт хийх боломжууд - Сумдын эдийн засгийг хөгжүүлэх - Үнэ цэнэ бий болгох, хуваалцах - Мал сүргийн эрүүл мэндэд анхаарах
4: Чанартай боловсролыг дэмжих	Боловсрол	Тэтгэлэгт хөтөлбөр, сургалт	- Шинэжинст сургуулийг “Эко сургууль” болгон өөрчлөх - Мэргэжлийн гадаад хэлний багш ажилд авах - Сургалтын тэтгэлэг
7 : Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх 9: Инноваци болон дэд бүтцийг хөгжүүлэх	Тогтвортой хөгжил	Тогтвортой хөгжил	- Эдийн засгийн үр ашиг - Сэргээгдэх эрчим хүч - Нөхөн сэргээлт - Хаалтын төлөвлөгөө - Дундын дэд бүтэц

Хүснэгт 7: Орон нутгийн болон компанийн оролцогчидтой ярилцлага хийхэд тавигдсан тулгамдсан асуудлууд – ашиг сонирхол давхардсан байж болно.

ДУГНЭЛТ

Монгол Улсад олборлох салбар чөлөөт зах зээлийн чиг хандлагаар үйл ажиллагаа явуулж байгаа нь харьцангуй шинэ юм. Уул уурхай, түүнийг дагалдах үйл ажиллагааны хязгаарлагдмал туршлага болон хувийн, төрийн бус уурхайн аж ахуйн нэгжүүд орон нутгийн иргэдэд салбарын талаарх буруу ойлголт, үл итгэлцлийг бий болгоход нөлөөлдөг байна. Дэлхийн⁴ олон өөр засаглалын системтэй улсуудын адилаар Монголд ч гэсэн уул уурхай сөрөг нэр хүндтэй байна (IRIM 2013). Уул уурхай төмөрлөг болон бусад материал үйлдвэрлэлээс нийгэм ашиг тус хүртэж байгаа ч Монголд уул уурхайн үр ашгийн талаарх олон нийтийн ойлголт хязгаарлагдмал байна. Судалгааны явцад ярилцлагад оролцогчид мөн судалгааны сэдвүүдэд уул уурхай уламжлалт зан заншил болон онцлог байдал ("identity") өөрчлөгдөхөд нөлөөлдөг талаар дурдсан (Жишээ нь, Мээстэрс & Бихагэл 2017; Ганболд & Али, 2017). Монголд авилгатай⁵ холбоотой гарсан мэдээллүүд олон улсын бизнесийн сүлжээнд Монголын талаар таагүй сэтгэгдлүүд төрүүлсэн. Монгол Улсын хууль эрх зүйн тогтворгүй байдал болон засаглалын асуудлууд хөрөнгө оруулагчдад давхар таагүй түгшүүрүүд төрүүлж байна. Ингэснээр, Эрдэнэ Ресурс өөрсдийн арга барил, түүхээс хамааралгүйгээр уул уурхайн салбарын тулгарч байгаа олон хүндрэл бэрхшээлийг сөрөн зогсох шаардлагатай болж байна.

Энэ судалгаагаар Эрдэнэ Ресурс нь оролцогч талуудтай сайн харилцааг үүсгэж сайн туршлагын үндэс суурийг тавьсан гэж үзэж байна. Мөн түүнчлэн, Эрдэнэ Ресурс нь харилцаагаа лавшруулан өргөжүүлснээр тогтвортой хөгжлийн агент болох боломж байгааг онцолж байна. Энэ стратеги дараах хоёр үр шимтэй. Нэгдүгээрт, Эрдэнэ Ресурсийн нийгмийн хариуцлагын хөрөнгө оруулалт нь цаашид бизнес болон орон нутагт үнэ цэнэ хүртээхээр үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлэхэд гол оролцогч талуудын итгэлийг олсон байна. Хоёрдугаарт, эдгээр хүчин чармайлтын үр дүнд төслийн техникийн эрсдэлээс гадна нийгмийн эрсдэлгүй болгосон гэдгийг хөрөнгө оруулагчид болон уурхайн цаашдын түншүүдэд харуулах боломжтой. "Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл" авах нь дэлхийн хэмжээнд уул уурхайн салбарын хамгийн том сорилтуудын нэг гэж тооцогдох болсон (E&Y 2018, PwC 2018). Хайгуулын компаниуд нь оролцогч талуудын тогтвортой харилцаа, хамтын ажиллагааны түншлэлийг бий болгосон гэдгээ тайлагнах чадвартай болсноор нийгмийн хөрөнгө оруулалтаар үүсч байгаа өгөөжийг тооцох боломжтой болно. Жишээ нь олборлолтод шаардлагатай усны хангамжийн эх үүсвэртэй байснаар үүсч болох эсэргүүцэлд алдсан үйлдвэрлэлийн сул зогсолтын өдөр байхгүй болно. Геологийн болон зах зээлийн зарчмуудыг авч үзвэл, нийгмийн дэмжлэг болон эерэг нөлөөлөл нь орон нутагт ч уурхайн түншүүдэд ч адил таатай, давуу нөхцөлийг бүрдүүлнэ.

Хийсэн ярилцлагын асуулгаас харахад Эрдэнэ Ресурс нь орон нутгийн оролцоог хангахаар тууштай ажиллаж байна. Ярилцлагын оролцогч бүр шахуу мэддэг бусад компаниудтай харьцуулахад Эрдэнэ Ресурсийг илүү сайн гэж үзсэн. Оролцогчид компанийн талаар сөрөг бодол илэрхийлээгүй.

⁴ Итгэлцэл, зөрчлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Globescan 2014 болон ICMM 2015 – аас үзнэ үү.

⁵ Жишээлбэл, Монгол Улсын засгийн газрын албан тушаалтнууд болон Оюу Толгойтой холбоотой авилгын талаарх 2018 оны хэвлэл мэдээллийн хамралтыг үзнэ үү.

Ярилцлагад оролцогчдоос уул уурхайн салбарын болон бусад салбарын төлөөллийн хэсэг нь орон нутагт хөрөнгө оруулсанаар орон нутагт бодит бус хүлээлт үүсч зарим тохиолдолд хүлээлтүүдийг зохицуулан удирдахад хүндрэл гардаг.

“Зэргэлдээ сум ч гэсэн уурхайтай, тэдгээр сумууд шинэ эмнэлэг, шинэ сургууль, усны хангамжтай. Тэд бодохдоо: Манай нутагт мөн уурхай байхад бид яагаад үр ашгийг хүртэхгүй байна гэдэг.”

“Рио Тинто [Оюу Толгой] анх төслийг удирдаж эхлэхэд авто зам, сургууль, эмнэлэг зэргийг байгуулах ёстой гэсэн хүчтэй шаардлагатай тулгарсан. Иймээс орон нутаг томоохон хүлээлттэй байсан.”

“Малчид Оюу Толгойгоос маш их хамааралтай болсон. Тэд Оюу Толгойгоос өндөр хүлээлттэй байсан.”

Эрдэнэ Ресурс нь “няхуур, нямбай” хандлагатай гэдгээрээ бусдад танигдсан бөгөөд энэ нь ч энэ мөчлөгт тохиромжтой гэж оролцогчид үзэж байна. Гэхдээ оролцогч талууд Эрдэнэ Ресурсийн төслүүдийг мөн адил Өмнөговийн бүс нутагт орших дэлхийн хамгийн том уурхайн нэг болох Оюу Толгойн төсөлтэй харьцуулах нь хүлээлтэд нөлөөлж болно. Оюу Толгой уурхайтай харьцуулж шаардаж болох хүлээлтийг, түүний дэргэд жижиг уурхай болох Баян Хөндий төсөл хангах боломжгүй бөгөөд энэ нь Эрдэнэ Ресурс тодорхой эрсдэлийг үүсгэх боломжтой. Тус компани төслүүдийнхээ хайгуулын үе шатанд үнэ цэнийг бий болгох, хуваалцах зорилгоор тогтмол уулзалт, хэлэлцүүлэг, хандалт, зорилтот хөрөнгө оруулалт хийсэн нь орон нутгийн оролцогч талуудын (магадгүй заримдаа бодит бус) өндөр хүлээлттэй ажиллахад чухал үүрэгтэй.

Ярилцлагуудаас тус компани нь итгэлцлийн тодорхой суурийг тавьсан нь харагдаж байна. Хэдийгээр бэрхшээл тулгарч болзошгүй боловч оролцогч талууд ямарваа асуудал гарахад компанитай тэр талаар ярилцах, хэрхэн ярилцахаа мэддэг байгаа нь судалгааны явцад тэмдэглэгдсэн. Дэлхийн уул уурхайн салбарын олон жишээнд оролцогч талууд зөвхөн дотроо ярилцсанаар хэт туйлширсан сөргөлдөөн үүсэх эрсдэлийг бий болгодог байна.

“Итгэл нь зарим үед их хэврэг байдаг. Итгэл алдрах асуудлууд үүсдэг. Гэсэн хэдий ч, сайн харилцаатай, оролцоотой, орон нутгийн дуу хоолойг сонсдог бол уурхайн эсвэл хайгуулын үе шатанд гарч болох асуудлыг даван гарах боломжтой.”

Судалгаанд оролцогчдын тодорхойлсноор усны чанар болон хэмжээ, түүнчлэн говь нутгийн газар ашиглалтын бусад өөрчлөлтүүдтэй холбоотой эрсдэл хамгийн өндөр хувьтай байгаа юм. Эдгээр нь зөвхөн Эрдэнэ Ресурсийн тулгарч буй эрсдэл биш бөгөөд IRIM-ын ОУСК-д зориулан гүйцэтгэсэн Өмнөговь аймгийн орон нутгийн усны хүртээмж, ашиглалт, менежментийн талаарх ойлголтыг үнэлэх судалгаанд усны чанар, хэмжээний талаар дахин дахин дурдсан байсан.

Судалгааны үеэр ярилцлагад оролцогч усны тухайд “Хүн болгонд хүрэлцэх ус байгаа болов уу?”, “Эрдэнэ Ресурс ус олбол малчид хэрэглэх байсан усыг компани авна гэсэн үг үү?” зэргээр асуудал тавьсан. Зарим хүмүүс гүний уснаас ус татах нь дахин нөхөгдөхгүйгээр бүх гүний усны хэмжээг бууруулдаг гэж санаа зовдог. Түүнчлэн Баянхонгор аймаг нь үйлдвэрийн хэмжээний (хэдийгээр бичил, хувиараа алт олборлолт хийгдэж байсан ч) уул уурхайн үйл ажиллагааны туршлага байхгүй.

Малчид усны чанар, хэмжээний талаар хамгийн их санаа зовж байсныг өмнө дурдсан. Ярилцлагад оролцогчид Эрдэнэ Ресурс нь худаг нөхөн сэргээсэн, зарим тохиолдолд шинэ худаг өрөмдөж гаргасан гэдгийг сайшааж байгаа

хэдий ч энэ хүчин чармайлт мал сүргийн усны хүртээмжид санаа зовж байгааг бууруулахгүй байна. Сүүлийн жилүүдийн цаг агаарын хатуу ширүүн нөхцөл байдал, үйлдвэрлэлийн эсвэл суурин газрын ус ашиглалтын талаарх туршлага байхгүй байгааг авч үзвэл энэ нь судалгааны хувьд гайхахаар үр дүн биш юм.

Цаашилбал, усны чанар, нийлүүлэлтийн асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хамтын ажиллагааны түншлэлийн боломжуудыг эрэлхийлэхийн зэрэгцээ малчдын тавьсан асуудлуудыг хүндэтгэн авч үзэх нь чухал. Дэлхийн түвшний уурхайн үйл ажиллагаа орон нутагт ямар үр ашигтай байх талаар таниулах шаардлагатай. Товчхондоо, компаниуд сайн сонсож, орон нутгийн оролцогч талуудтай байнга харилцаж байх хэрэгтэй.

Судалгаагаар оролцогч талуудын оролцоог хангах ач холбогдлын талаар компанийн бүх түвшинд (гүйцэтгэх шатны ажилчдаас ахлах удирдлага болон Захирлуудын Зөвлөл хүртэл) мэдэж байна.

“Монгол Улсад ажиллахдаа бид хэдэн мянган жилийн туршид нүүдэлчин маягаар амьдарсан малчин соёл, малчидтай харилцдаг, тэр соёлыг хүндэтгэх хэрэгтэй.”

Орон нутгийн оролцогч талууд цөөн тооны тодорхой хувь хүмүүсийг компанийн гол төлөөлөл гэж үзэж байна. Энэ нь эерэг ба сөрөг үр дагавартай. Нэг талаараа энэ нь харилцаа холбоог сайжруулж, байнгын холбоог баталгаажуулж, харилцан итгэлцлийг бий болгодог. Нөгөө талаараа энэ нь Монголын хөдөө орон нутагт нийтлэг нүүдэлчин, биеэ даасан соёлоор тухайн цөөн төлөөллөөс компанийн шууд хамаарал үүсэх эрсдэлтэй. Компани цаашид өргөжих тусам байгууллагын хэмжээнд харилцааг бүх үйл ажиллагааны чиглэлд үргэлжлүүлэн бий болгох нь чухал. Эрдэнэ Ресурс төслийн эхний үе шатнаас орон нутгийн харилцаа хариуцсан ажилтнууд ба төслийн талбайд оролцогч талуудын оролцоог хангах эрүүл мэнд, ХАБ-ын ажилтнууд, байгаль орчны байцаагч томилогч ажиллуулсан нь салбарын оролцогч талуудын дунд сайшаагдсаныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь компанийг Баянхонгор аймагт үргэлжлүүлэн үйл ажиллагаа явуулахад дэмжлэг болно. Төсөл хэрэгжих явцад ажилтнуудын орон нутгийн харилцаа, оролцоог хангах үр чадварын сургалт явуулбал ашиг тустай байх болно. Бусад компаниудын хувьд тэдний геологичид, уурхайн инженерүүдийн тухайд олон гомдол ирдэг нь орон нутгийн оролцогч талуудтай хамтран ажиллах шаардлага их тулгардаг ч энэ чиглэлээр сургалтанд хамрагдаж үр чадвараа сайжруулаагүйгээс амжилттай хамтран ажиллаж чадахгүй байгаагаар холбоотой.

Монголын хөрөнгийн биржид үнэт цаасыг давхар бүртгүүлэн, Баян Хөндий төсөлд хамгийн ойр хоёр сумын иргэдэд компанийн хувьцааг худалдан авч, өөрийн нэр дээр бүртгүүлэх боломжийг олгосон Эрдэнэ Ресурсийн шийдвэр нь орон нутгийн иргэдэд хүртээж буй бодит үр ашиг болсон талаар орон нутагт хийсэн ярилцлагад оролцогчид онцолсон. Ярилцлага өгсөн хэд хэдэн оролцогч орон нутгийн иргэдэд хувьцаа санал болгох нь нийтлэг үнэ цэнийг хуваалцах тодорхой жишээ мөн гэж үзжээ.

Судалгааг дүгнэж үзэхэд, хайгуулын компаниудад нь үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа үнэ цэнийг бий болгож, хуваалцах боломж байна. Эрдэнэ Ресурсийн сайн туршлага, амжилт нь дараах дөрвөн гол хүчин зүйлтэй холбоотой байна. Үүнд:

1. **Алсын хараа:** Компанийн удирдлага оролцогч талуудын оролцоог хангах болон тогтвортой хөгжлийн ач холбогдлын талаар тодорхой тусгасан алсын харааг баталсан. Компанийн бүхий л түвшинд үүнийг хүлээн зөвшөөрөн дагаж мөрддөг. Эрдэнэ Ресурстай адил компани алсын харааг хэвээр хадгалж байгаад сайшаалтай. Компани хөгжих тусам уурхайн бүтээн байгуулалтад шаардлагатай нэмэлт хүн хүчийг харгалзан энэ алсын харааг хамгаалан бэхжүүлж байх хэрэгтэй.
 2. **Харилцаа:** Зөвхөн богино хугацааны хамтын ажиллагаа бус, аль болох эртнээс оролцогч талуудын оролцоог хангах, харилцааг бий болгоход цаг хугацаа зарцуулах хүсэл эрмэлзэлтэй байх хэрэгтэй. Эрдэнэ Ресурс нь Монгол Улсад урт хугацаанд үйл ажиллагаа явуулан эрүүл, уян хатан харилцааг үндэсний болон орон нутгийн түвшинд, мөн олон улсын хөрөнгө оруулагчидтай бий болгох хүчин чармайлт гаргаж ирсэн тул оролцогч талуудад танигдан хүлээн зөвшөөрөгдсөн.
 3. **Стратеги:** Компанийн нөөц болон тухайн төслийн хувьд уурхайн мөчлөгийн үе шатанд тохирсон бөгөөд бодитой үр ашиг хүртээх орон нутгийн харилцааны хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлэх хандлага бүхий стратегитай.
 4. **Хүмүүс:** Орон нутгийн оролцоог үр дүнтэй хангахад зориулан ажилтнуудыг сургах, хүний нөөцөд хөрөнгө оруулах нь компанид илүү зардал гэж үзэгддэг бол энэ нь Эрдэнэ Ресурсийг бусад хайгуулын компаниудаас ялгаруулах давуу тал болж байна.
-

ЗӨВЛӨМЖ

Судалгааны зөвлөмжийг хоёр бүлэгт ангилав. Үүнд: 1) Бизнес стратеги, болон 2) Харилцаа холбоо.багтана.

БИЗНЕС СТРАТЕГИ

Судалгаагаар Эрдэнэ Ресурс нь нийгмийн хариуцлагын чиглэлээр дэвшилтэт үзэл баримтлалтай бөгөөд компанийн тогтвортой хөгжлийн алсын хараа компанийн хэмжээнд тогтсон гэж дүгнэв. Тухайлбал, Гүйцэтгэх удирдлага, ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд хүртэл оролцогч талуудын оролцоог хангах ажиллагааны ач холбогдлын талаар нэгдсэн байр суурьтай байсан.

Эрдэнэ Ресурсийн өнөөгийн түвшинд танигдсан байдал, төсөлд хамгийн ойр аймаг, сумдад олсон нэр хүндийг (бүс нутгийн ашиг сонирхолд хувь нэмэр оруулахад итгэж болох компани гэх мэт) авч үзэхэд, Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий болон Алтан Нар төслүүдээ хөгжүүлэх үүднээс нийгэмд үзүүлж буй эерэг нөлөөллөө бататгах боломжтой нь харагдаж байна.

Компани үргэлжлүүлэн бүх оролцогч талуудад үнэ цэнийг бий болгон хуваалцахын тулд дараах гурван санаачилгыг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

- Оролцогч талуудын оролцоог хангах, тогтвортой хөгжил болон хамтын үнэ цэнийг хуваалцах талаар стратеги боловсруулах, хөгжүүлж байгууллагын бодлогод нэгтгэх шаардлагууд боловсруулах

Онолын хувьд “social chain of custody” нэрлэгддэг энэ төлөвлөгөө нь нэр хүндтэй холбоотой капиталын бодлогыг тогтооно. Энэ нь шинэлэг практик бөгөөд уул уурхайн хайгуулын мөчлөгөөс, уурхай байгуулах, цаашлаад уурхай хаах хүртэл үе шатуудад төслийг хэрэгжүүлэх явцад хэрхэн итгэл олох, хүлээх асуудлуудыг болон цаашдын хөгжүүлж болох түншлэлийн талаар авч үздэг.

Компанийн удирдлагаас баталж, Эрдэнэ Ресурсийн ерөнхий бизнесийн стратегид нийцүүлснээр нийгмийн нөлөөллийн стратеги нь Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн бүтээн байгуулалт, барилга угсралт болон хаалтын үе шатуудад оролцогч талуудын харилцаа болон компанийн нэр хүндийг хамгаалах юм. Стратегийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ирээдүйн төслийн аливаа хамтрагч нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэн нийтлэг үнэ цэнийг бий болгоход оршино.

Мөн стратегийн гол оролцогчдын нэг нь ажилтнууд гэж үздэг. Эдгээр ажилтнууд нь Компанийн нэр хүндийг хамгаалах голлох төлөөлөл болох боломжтой. Ажилтнуудад компанийн өөрчлөгдөн шинэчлэгдэж буй бизнесийн стратегийн талаар тодорхой ойлгуулж, компанийг төлөөлөхөд шаардлагатай ур чадвар, нөөцөөр хангахыг зорих хэрэгтэй. Цаашид Компанийн ажилтнуудын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр бизнесийн стратегийг тайлагнах, танилцуулах албан үйл явц байх шаардлага гарна.

Ашигт малтмалын хайгуулын үе шатанд компанийн нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх гэдэг нь шинэ чиглэл бөгөөд амжилттай жишээг дурдахад төвөгтэй. Гэхдээ бизнесийн амжилтад нэр хүндийн ач холбогдлын талаар нэлээд судалж тэмдэглэгдсэн байдаг (Экклс, Ньюквист & Шатц, 2007).

- **Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн ханган нийлүүлэлтэд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдийг түлхүү оролцуулах**

Уурхайн бус ажиллагаанд дэмжлэг үзүүлэх буюу мал аж ахуй болон байгаль орчны салбар дахь оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй (жишээ нь: бэлчээрийн тэнцвэртэй байдлыг хангахад малчдад туслах, эсвэл мал сүргийн эрүүл мэнд, хамгааллыг сайжруулах). Орон нутагт явуулсан ярилцлагын үр дүнгээс харахад Баянхонгор аймагт уурхайн шууд болон шууд бус ханган нийлүүлэлтийн сүлжээнд оролцон олон төрлийн нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх сонирхол нэлээд байна. Жишээлбэл: нөхөн сэргээлтийн асуудал нэлээд хөндөгдсөн бөгөөд бичил уурхайчид болон зөвшөөрөл эзэмшигчид хайгуул хийгээд нөхөн сэргээлгүй үлдээсэн талбайнуудыг нөхөн сэргээх хэрэгтэй талаар яригдсан. Тиймээс энэ нь холбогдох үүрэг хариуцлагыг илүү хэрэгжүүлдэг болсон үед шинэ бизнес хөгжүүлэх боломж байж болох юм.

Зарим нэмүү өртөг бүтээх санаачилгууд нь Эрдэнэ Ресурсийн хэрэгцээ болон бүсийн оролцогч талууд хоорондын ашиг сонирхлууд нэгдмэл байж болох юм. Үүнд хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулах, эрчим хүчний аюулгүй байдлыг хангах, суурингуудад ундны ус нийлүүлэх дэд бүтэц зэргийг сэргээгдэх эрчим хүчтэй нэгтгэх хамаарна. Энэ хэсэгт Эрдэнэ Ресурс аль хэдийн тодорхой алхмуудыг хийж, боломжуудыг судалж эхэлсэн.

Эргэлтийг бууруулан үр ашиг хуваах, уул уурхайн бизнесийн нийгмийн эрсдэлийг бууруулахад зорилтот, цагаа олсон, орон нутгийн агуулга бүхий бодлого, тэр дундаа ажиллах хүчийг хөгжүүлэх, худалдан авалт, барилга байгууламж зэрэгт чиглэсэн бодлогууд ач холбогдолтой.

Нэмүү өртөг бүтээх санаачилгууд – жишээлбэл: ноолуурын салбарт (угааж самнах) компани шууд нийтлэг үнэ цэнэ хуваалцах боломжуудыг санал болгохгүй боловч орон нутгийн гэр бүлүүдийн орлогын үндсэн эх үүсвэрийг нэмэгдүүлэх үүднээс энэ төслийг дэмжих хэрэгтэй.

Компани нь орон нутгийн малчдад төрөл бүрийн чанартай ноолуурын бизнесийн эсвэл маркетингийн төлөвлөгөө боловсруулах, эсвэл хайгуулын/уурхайн кемпэд шаардагдах махны хэрэгцээг хангах хүсэлтэй малчдыг дэмжих зорилгоор малчдад туслах техникийн туслалцаа (эсвэл санхүүжилт) үзүүлэх боломжтой. Түүнээс гадна ярилцлагын үеэр иргэдийн анхаарал хандуулж байсан асуудал нь бичил уурхайн нөлөөллөөс үүссэн болон нөхөн сэргээлтийн шаардлага хангаагүй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаар санал гомдол байсан.

Мөн Эрдэнэ Ресурс нь гэрээт гүйцэтгэгч компаниудын үнийг өрсөлдөхүйц хэмжээнд хүргэхийн тулд буцах чиглэлийн хувилбаруудыг (уурхайн талбайд нийлүүлэлт хүргээд Улаанбаатар хот руу ачаагүй буцдаг ачааны машинуудын хувьд) судлан аймгийн төв болон Улаанбаатар хотод зах зээлээ хөгжүүлэх хүсэлтэй орон нутгийн бизнесүүдийг дэмжин тээвэрлэлт хийж өгөх шаардлага тавьж болно. Мэдлэгжүүлэх болон чадваржуулах ажилд нөөц гаргаж, энэ талаарх боломжуудыг эрэлхийлэх нь уурхайн бүтээн байгуулалт болон түүний дараагийн үе шатуудад, тухайлбал, уурхай, уурхайн ханган нийлүүлэлт, бусад бизнесийн чиглэлүүдийг хөгжүүлж, компанийн нэр хүндийг бэхжүүлэх (аялал жуулчлал гэх мэт) үр дүнтэй арга болно.

- **Усны менежмент: Төслийн бүтээн байгуулалтын явцад компани усны менежментийн тогтолцоо, менежментийг үйл ажиллагаандаа үргэлжлүүлэн хөрөнгө оруулалт хийх нь Эрдэнэ Ресурс нийгмийн зөвшөөрлөө хадгалахад зайлшгүй хэрэгтэй.**

Бүх оролцогч талууд усыг онцлон авч үзэж байгаа тул Эрдэнэ Ресурс хариуцлагатай ус хэрэглэгч гэдгээ харуулсаар байх нь чухал. Баянхонгор аймгийн орон нутаг, оролцогч талуудын төлөө гаргасан компанийн хүчин чармайлтаас гадна ОУСК-аас дэмжиж буй усны сайн дурын кодексын дугуй ширээний хэлэлцүүлэгт идэвхтэй оролцож байгаа нь (<https://www.commddev.org/south-gobi-water-and-mining-industry-roundtable/>) энэ тал дээр бусад компаниудын туршлагаас суралцахад ач тустай.

Усны чанар, хэмжээний талаарх ойлголтыг баримт, шинжлэх ухааны тайлбараар няцаах нь хүндрэлтэй байдаг. Учир нь иргэдэд бодит туршлагаар харуулах боломжтой байдаг. Бүс нутгаас баг, сумын төлөөлөгчид оролцуулсан усны хяналтын хороог байгуулан нийгмийн эрсдэлийг бууруулах, мэдлэгийг бий болгох стратеги хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Хяналтын хорооны үүрэг, хариуцлагыг төслийн явцтай уялдуулж болох юм. Жишээ нь: худагруу аялал хийх гэх мэтээр эхлэн цаашлаад усны хяналт, шинжилгээ хүртэл илүү цогц арга барилд шилжиж болно.

ХАРИЛЦАА ХОЛБОО

- Салбарын талаар оролцогч талуудыг үргэлжлүүлэн мэдлэгжүүлэх

Томоохон уул уурхайн үйл ажиллагаа нь орон нутагт шинэ учраас ашигт малтмалын хайгуул, олборлолтын үе шатууд, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ, уул уурхайн орон нутгийн болон улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрт оруулж байгаа хөрөнгө оруулалтын үр шим зэргийн талаар иргэд, оролцогч талуудыг мэдлэгжүүлэх хэрэгтэй.

“Тэд хайгуул гэж юу болох, яагаад чухал болохыг орон нутгийн иргэдэд таниулах хэрэгтэй. Бидэнд үндэсний хэмжээнд геологийн сайн мэдээлэл байхгүй. Бүх мэргэжилтнүүд энэ талаар мэддэг. Орон нутгийн түвшинд энэ талаар мэдлэг мэдээлэл байхгүй. Тэд хайгуулын төслүүдээс их ашиг олддог гэж боддог.”

Эрдэнэ Ресурс нь орон нутагтай үүсгэсэн харилцаа болон орон нутагт үзүүлж байгаа хөтөлбөрүүдээрээ бусдад танигдаж чадсан. Орон нутгийн эдгээр хөтөлбөрүүдийг Монгол хэлээр оролцогч талуудад хүргэснээр төслүүдийн үр шимийг нэмэгдүүлэх боломжтой. 2017 оны Сант Маралын хийсэн судалгаанаас үзэхэд, нийслэлийн оршин суугчдын 52 хувь, Улаанбаатар хотын оршин суугчдын 69 хувь нь Фейсбүүк хэрэглэгчид байна. Тиймээс Эрдэнэ Ресурс нь дижитал платформ болох Фейсбүүкийг харилцааны хэрэгсэл болгон ашиглаж болох бөгөөд Монгол хэл дээрх хуудсыг бий болгож, орон нутгийн иргэдэд одоогийн үйл ажиллагаануудын талаар болон уурхайн бүтээн байгуулалтын төлөвлөсөн хугацаа зэргийн талаар мэдээлэх боломжтой. Энэ платформыг дээр дурдсан сургалтын материалуудыг тавих, таниулах эсвэл тэдгээр сургалтын материалтай холбоход хэрэглэж болно.

Орон нутгийн уулзалт болон айл өрхүүдээр зочлох нь компани ил тод үйл ажиллагаа явуулдаг, мөн зөвхөн элитүүдэд биш харин бүх оролцогч талуудад үр ашиг хүртээдэг гэдгийг танилцуулж байгаа чухал алхам юм. Ингэснээр орон нутгийн нөлөө бүхий хүмүүстэй ганцаарчлан уулзалт хийх нь орон нутагтай үүсгэж байгаа үндсэн харилцаа холбоо гэдэг арга барилыг үгүйсгэж сөрөг ойлголтыг багасгана. Уламжлалт маягаар танхимд уулзалт зохион байгуулахын оронд Эрдэнэ Ресурс бусад оролцооны тактикуудыг судлан орон нутгийг чадваржуулахад чиглэсэн уурхайгаас гадуур чухал сэдвүүдээр орон нутгийн нээлттэй өдөрлөг, хуралдаан (тухайлбал, хөрөнгийн зах зээлийн мэдээлэл, тээврийн төлөвлөлт гэх мэт) зохион байгуулж болно. Орон нутгийн хамтын ажиллагааны хороодтой хамтарч ажилласнаар тодорхой форум үүсгэж жилийн ажлаа тайлагнах нь заал танхимд хийх хурлаас үүсдэг хэт туйлширсан байдлаас сэргийлж болох давуу талтай.

- Өргөдөл, гомдол барагдуулах үйл явц

Орон нутгийн иргэд санал гомдлоо Эрдэнэ Ресурсийн хариуцсан хүнд хүргэдэг ч компанийн албан ёсны өргөдөл гомдол барагдуулах үйл явцыг мэддэггүй байна. Монгол ахуйн харилцааны соёл нь аман хэлбэртэй байдаг хэдий ч орон нутгийн санал гомдлыг баримтжуулж, шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч байгааг бүртгэж тэмдэглэх нь компанид болон ирээдүйн хөрөнгө оруулалтын түншүүдэд чухал мэдээлэл болно. Энэ төрлийн баримт бичгийн бүрдүүлэлтийг хөнгөвчлөх боловсронгуй программ хангамж⁶ ч байдаг. Гэхдээ төслийн өнөөгийн үе шатанд одоо байгаа протоколууд хангалттай. Компаниудын хувьд санал гомдлын тоо нь төсөл өргөжих тусам нэмэгддэг. Уурхайн бүтээн байгуулалтын үе шатанд хамгийн их маргаан бүртгэгдсэн нь 2014 онд хийгдсэн судалгаагаар тогтоогджээ (Davis & Franks, 2014). Энэ шалтгааны улмаас Эрдэнэ Ресурсд өргөдөл, гомдол барагдуулах үйл явцыг нягтлан шалгаж энэ явцыг сайжруулж байхыг зөвлөж байна.

⁶ Жишээ нь <https://www.sustainet.com/stakeholder-management-software/> ба <https://www.boreal-is.com/blog/grievance-management-mechanisms-en-system/>



- Байгууллагын веб дээр орон нутгийн хуудас бий болгох

2018 онд гаргасан Эрдэнэ Ресурсийн шинэ веб нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, хууль эрх зүйн байгууллагуудад, агентлагуудад зориулан Англи болон Монгол хэл дээрх дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан байна. Гэхдээ энд орон нутгийн оролцогч талуудад зориулсан мэдээлэл алга. Зарим компаниуд байгууллагын веб хуудастай холбоотой тусдаа төслийн цахим хуудас сонгон хийлгэдэг. Бусад нь байгууллагын веб хуудас дээр тусдаа хэсэг үүсгэдэг.

Хайгуулаас барилга угсралтын үе шат руу шилжихдээ компаниуд ихэвчлэн төслийн тусдаа веб хуудас бий болгодог. Ийм сайтууд нь ихэвчлэн твиттер, фейсбүүк гэх мэт бусад дижитал платформуудтай зохицдог боловч агуулгадаа байгууллага хатуу хяналт тавьдаг. Веб хуудас нь олон оролцогч талууд компанийн талаар тодорхой мэдээлэл хайдаг, нийтлэг харилцааны платформ юм.

Байгууллагын веб хуудас дээр нэмэлт орон нутгийн хуудас гаргах эсвэл төсөлд зориулсан вэб хийхээс үл харгалзан мэдээллийг Монгол хэл дээр техникийн бус, энгийн хэллэгээр танилцуулан бичих нь зүйтэй (жишээлбэл, 6-р ангийн сурагчийн унших түвшинд). Агуулгад дараах зүйлсийг оруулж болно. Үүнд:

- Орон нутагт ивээн тэтгэсэн төслүүдийн зургууд/видео;
- Орон нутгийн санхүүжилт авсан хүмүүсийн ярилцлага;
- Компаниас нөхөн сэргээсэн, эсвэл компаниас өрөмдсөн шинэ худгийн байршлуудыг харуулсан интерактив газрын зураг;
- ОУСК, ТББ-ын түншүүд, хөгжлийн агентлагууд болон/эсвэл уул уурхайн холбоод гэх мэт гуравдагч талын боловсруулсан олон нийтэд зориулсан сургалтын материалуудын холбоосууд;
- Уурхайн төслийн үе шатуудыг харуулсан график зургууд; сонирхогч талууд энэ салбарт ажиллах карьераа төлөвлөхөд зориулж, хайгуулын болон олборлолтын ажлын төрлүүдэд шаардлагатай ур чадварууд болон нээлттэй ажлын байрууд;
- Тогтвортой хөгжлийн санаачилгуудын дэлгэрэнгүй мэдээлэл;
- Орон нутгийн хамтын ажиллагаа хороо эсвэл орон нутгийн мэдээлэл хүргэх уулзалтуудын тэмдэглэлүүд;
- Орон нутагт хөрөнгө оруулах санхүүжилтийн анкет;
- Усны хяналтын хөтөлбөр зэрэг санаачилгуудад хэрхэн оролцох талаарх мэдээлэл.



ЦААШДЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

Эрдэм шинжилгээний зүгээс нийгмийн хариуцлагын шатлалыг цаашид судлах шаардлагатай. Орон нутгийн оролцоог хангах хөтөлбөр эхлэхдээ богино хугацааны зорилготой хөрөнгө оруулалтаар эхэлдэг бөгөөд энэ нь харилцааг үүсгэн илтгэлийг бий болгоход чухал алхам юм. Энэ харилцаа бэхжихэд нийгмийн хариуцлагын стратегийн хэлбэрүүдэд шилжин, илүү боловсронгуй болгож НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудад ойртоход Портер болон Крамерийн нийтлэг үнэ цэнийн үзэл баримтлалыг хэрэглэх боломжтой. Урт хугацаат нийтлэг үнэ цэнийг бий болгохоор хамтын ажиллагааны түншлэлийг үүсгэн санхүүжүүлэх нь хайгуулын компаниудын хувьд хэцүү байж болох боловч судалгааны дүгнэлтээр энэ нь шилжилтийн алхам болж байна. Энэ алхам нь уламжлалт компанийн нийгмийн хариуцлагаас (CSR) илүү стратегийн ач холбогдолтой бөгөөд ашиг сонирхол давхацсан асуудлууд дээр хамтран ажиллах, оролцогч талуудын оролцоог сайжруулах, нэр хүндийн хөрөнгө босгох, үнэ цэнийг нэмэгдүүлэх, нийгмийн эрсдэлийг бууруулах боломжийг бий болгоно. Баян Хөндий болон Алтан Нар төслүүдээ Эрдэнэ хэрхэн үргэлжлүүлэн хэрэгжүүлэхийг ажигласнаар судлаачид компаниуд уурхайн үйл ажиллагааны үе шатуудад болон байгууллагын өөрчлөлтийн явцад "social chain of custody" бий болгож байгааг өвөрмөц өнцгөөс харж ойлголт авах боломжтой.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Судалгааны үр дүн болон зөвлөмжийн талаар асуулт байвал доор заасан төслийн багт хандан хариулт авч болно.

Доктор. Надя Күнз
Туслах профессор
nadj.kunz@ubc.ca

Доктор. Жосеф Фрейзер
Докторын дараах судлаач
jocelynfraser@shaw.ca

Булган Батдорж, ШУМ
Судлаач
bulgan.batdorj@gmail.com

Нийгмийн Бодлого, Олон Улсын Харилцааны Сургууль,
Норман Б.Кийвэл Уул Уурхайн Инженерийн Сургууль
Бритиш Колумбын Их Сургууль | Ванкуверийн Кампус

Энэхүү судалгаа нь Эрдэнэ Ресурс Хөгжлийн Корпораци болон Канадын ашгийн бус байгууллагаас санхүүждэг MITACS -ийн санхүүжилтээр хэрэгжүүлж, судлаачдыг онолыг дэлхийн бодит хэрэглээнд ашиглах боломжийг хангаж, өндөр чанартай, бие даасан судалгааны компаниудыг татан оролцуулах зорилготой юм. <http://www.mitacs.ca/en/programs/accelerate>

Энэхүү судалгааны Англи хувилбар болон Монгол хэл дээрх орчуулгад зөрүү гарвал Англи хэл дээрх эх хувь нь жинхэнэ, дагах эх нь байна. Монгол хэл дээрх орчуулга нь зөвхөн олон нийтэд мэдээлэл хүргэх, танилцуулахад зориулагдсан болно.

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

Дэвис, Р. & Френкс, Д. (2014). Ашигт малтмалын салбар дахь компани болон орон нутгийн зөрчлийн өртөг. https://sites.hks.harvard.edu/m-rcbg/CSRI/research/Costs%20of%20Conflict_Davis%20%20Franks.pdf

Иклс, Р., Ньюквист, С., & Шатц, Р. (2007). Нэр хүнд ба түүний эрсдэлүүд. Харвардын бизнес сэтгүүл, 2-р сар, 104-114. <https://hbr.org/2007/02/reputation-and-its-risks>

ЕҮ (2018). Уул уурхай ба төмөрлөгийн бизнесийн эрсдэлүүд. <https://www.ey.com/gl/en/industries/mining---metals/business-risks-in-mining-and-metals>

Фрейзер, Ж. (2018). Уурхайн компаниуд ба орон нутаг: Нийгмийн эрсдэлийг бууруулах ба тогтвортой хөгжлийг урагшлуулах хамтарсан арга барил. Нөөцийн бодлого. Цахим хэвлэл: 16-FEB-2018 DOI мэдээлэл: 10.1016/j.resourpol.2018.02.003

Ганболд, М., & Али, С., (2017). Нөөцийн үндэстний амлалт ба аюул: Монгол Улсын уул уурхайн бүтээн байгуулалтын кейс шинжилгээ. Нөөцийн бодлого, 53, 1-11.

Globescan (2014). Уул уурхайн салбарын тайлан <https://www.icmm.com/en-gb/publications/public-perceptions/2014-icmm-stakeholder-survey>

Монгол Улсын засгийн газар (2016 оны 2-р сарын 5). Монгол Улсын их хурлын (Парламент) тогтоол: Монгол Улсын тогтвортой хөгжлийн алсын хараа – 2030 он хүртэл батлав.

ICMM (2015). Хураангуй: Компани болон орон нутгийн зөрчлийн талаарх судалгаа. <http://www.icmm.com/website/publications/pdfs/social-and-economic-development/8515.pdf>

IRM - ОУСК болон Монгол Улсын бие даасан судалгааны институт (2015). Өмнөговь аймгийн усны талаарх асуулга судалгааны гол үр дүн (2013): 2015 хэлэлцүүлгийн танилцуулга. Татаж авах <https://www.commddev.org/wp-content/uploads/2015/05/IRIM-BOOKLET-FINAL-ENG-PRINTED.pdf>

Мийстерс, М., & Бихагел, Жэй., (2017). Үйл ажиллагаа явуулах нийгмийн зөвшөөрөл: Аюулыг саармагжуулах ба зогсоох. Нөөцийн бодлого, 53, 274-282

PwC (2018). Хүлээсэн цаг хугацаа. <https://www.pwc.com/gx/en/mining/assets/pwc-mine-report-2018.pdf>

Портер, М., & Крамер, М. (2011). Нийтлэг үнэ цэнэ бүтээх: Капитализмыг хэрхэн дахин бий болгох вэ – ба инновац, өсөлтийн давлагааг эхлүүл. Харвардын бизнес сэтгүүл 89 (1-2), 62-77.

Сант Марал сан (2017 оны 3-р сар) Улс төрийн барометр. #16 (50). Нэвтэрсэн: 7-р сарын 28 <http://www.santmaral.org/publication>

ДЭМБ/НҮБ-ын Хүүхдийн сан (2015). Усны хангамжийн хяналтын хөтөлбөр|| Эрүүл ахуй ба ариун цэвэр. Нэвтэрсэн: 2018 оны 7-р сарын 28 http://www.unwater.org/publication_categories/whounicef-joint-monitoring-programme-for-water-supply-sanitation-hygiene-jmp/

ХАВСРАЛТ А: ЭРДЭНЭ РЕСУРС КЭЙС СУДАЛГААНЫ ЧАНАРЫН ЯРИЛЦЛАГЫН УДИРДАМЖ

Бритиш Колумбын Их Сургууль нь олон улсын уул уурхайн салбар дахь компанийн нийгмийн хариуцлагын практик хандлагуудыг болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын хэрэгжилт сэдвээр судалгааны ажлыг хийж байгаа болно. Түүнчлэн судалгааны ажлын үндсэн асуулт нь уурхай барьж олборлолтруу шилжихээр ажиллаж байгаа хайгуулын компаниуд тухайн орон нутаг, засгийн газар, компанидаа хэрхэн үнэ цэнэ бүтээж түгээж, ашгийг нэмэгдүүлэх вэ гэдгийг олж мэдэх зорилттой байгаа юм. Таны өгөх хариултад зөв эсвэл буруу гэсэн дүн байхгүй бөгөөд хэрвээ та хариулахыг хүсэхгүй бол бид тухайн асуултыг алгасаж дараагийн асуултад шилжиж болно.

1. Өнөөдрийн байдлаар танай (орон нутаг/ компани/ салбар)- т тулгамдаж буй хамгийн чухал асуудал юу вэ?
[Та яагаад ингэж бодож буйгаа хэлж болох уу?](#)
2. Таны бодлоор уул уурхайн олборлолтын өмнөх хайгуулын үе шатанд а) танд, б) танай орон нутагт, с) танай улсад хэрхэн ямар үр нөлөөлөл гарах вэ?
[Эерэг, сөрөг, саармаг, мөн тэдгээр нь залруулах боломжтой болон залруулах боломжгүй зэрэг](#)
3. Та ашигт малтмалын хайгуулын болон уул уурхайтай холбоотой туршлагаасаа хуваалцаж болох уу?
[Тухайн хүний туршлагыг тодорхойлох: ажилтан, ханган нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ, ажиглагч, зохицуулагч, иргэн, хөгжлийн агентлаг, төрийн бус байгууллага; хэдэн жилийн туршлагатай эсэх; эерэг болон шүүмж хандлагатай эсэх гэх мэт.](#)
4. Хайгуулын компани тухайн ордтой ойролцоох орон нутгийн иргэдтэй ямар төрлийн харилцаатай байх нь зохистой вэ? Та надад жишээ хэлж болох уу? Энэ харилцаа уурхай барих болбол өөрчлөгдөх үү? Хэрвээ тийм бол хэрхэн өөрчлөгдөх вэ?
[Уул уурхайн бий болгох өгөөжийн хүлээлтийг үнэлэх - орон нутгийн ивээн тэтгэгч/ өглөг өгөх хэлбэрээр хөрөнгө оруулах, нэгдэн ажиллах хамтрагч, ажлын байр, сургалт, чадавхыг бэхжүүлэх.](#)
5. Уул уурхайн салбарт компанийн үнэ цэнэ бүтээх түгээх үүнээс улбаалан тогтвортой хөгжлийг дэмжихийг чухалчлан авч хэлэлцдэг. Таны бодлоор уул уурхай салбар үнэ цэнэ бүтээх түгээх гэдэг санаа хэрхэн ойлгогдож байна? Энэ нь танд юу гэсэн үг болох вэ?
[Орон нутагт үнэ цэнэ үүсгэх түгээх төслүүд, санаачлага зэргийн жишээ. Мөн эдгээр санаачлага төсөл нь КНХ төсөл гэж тооцогдох уу хэрвээ үгүй бол ямар ялгаатайг шинж.](#)

2-р хэсэг: Эрдэнэ Ресурсийн тухай тусгайлсан асуултууд

6. Эрдэнэ Ресурсийн талаар танаас хэдэн асуулт асуух гэсэн юм. Эрдэнэ Ресурс ХХК гэж та сонссон уу? Хэрэв тийм бол үргэлжлүүлэх, хэрэв үгүй бол асуулт 10-руу шилжих. Эрдэнэ Ресурс ХХК-ийг таны мэдэх бусад хайгуулын компаниудтай харьцуулан үзвэл:
 - ☐ Өөр компаниудтай огт адилгүй
 - ☐ Бараг ижил
 - ☐ Эрдэнэ сайн (Юугаараа?)
 - ☐ Эрдэнэ муу (Яагаад ингэж үзэж байгаа вэ?)
7. Эрдэнэ Ресурс-ийн талаарх таны сэтгэгдэл? Та яагаад ингэж үзэж байна?
 - ☐ Тун таатай
 - ☐ Таатай
 - ☐ Мэдэхгүй
 - ☐ Таагүй
 - ☐ Үнэхээр таагүй

8. Та доорх асуултуудад хариулж өгнө үү.

Эрдэнэ байгаль орчинд зохистойгоор үйл ажиллагаа явуулдаг.

Тийм Мэдэхгүй Үгүй

☐
☐
☐

Эрдэнэ орон нутагтай зохистой харилцаа холбоотой байдаг.

☐
☐
☐

Тус төслийн удирдлагад нь таны итгэж болох хүмүүс байдаг.

☐
☐
☐

Тус компани нь орон нутгийн шаардлагад анхааралтай ханддаг.

☐
☐
☐

Эрдэнэ орон нутагт өгсөн амлалтдаа хүрдэг.

☐
☐
☐

Эрдэнэ ашиглах боломжтой орд олох нь танай орон нутагт ашигтай

☐
☐
☐

9. Эрдэнэ Ресурсийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн орон нутгийн төслүүдээс мэдэх үү? Үгүй ☐ Тийм ☐
а. Хэрэв тийм бол та надад тэр/ тэдгээр төслүүдийн талаар товчхон хэлж өгнө үү?

Тогтвортой хөгжлийн зорилтууд

10. Уламжлалт хэлбэрийн орон нутгийн хөрөнгө оруулалт болон санхүүжилт зэргээс гадна зарим орон нутгууд өөрсдийн бүс нутгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг дэмжихийг уул уурхайгаас шаардаж байна. Энэ нь зарим газруудад цэвэр эрчим хүчний санаачлага, усны зохистой удирдлага эсвэл хамтын дэд бүтэц гэх мэт төслүүдэд хамтрах түншлэлийг бий болгосон. Танай орон нутагт магадгүй уул уурхай нь түншлэгч хэлбэрээр хамтран ажиллаж болохуйц иймэрхүү төрлийн төсөл хөтөлбөрүүд байгаа юу?

Төгсгөх асуултууд

11. Эрдэнэ Ресурсийн “Баян Хөндий” нэртэй алтны ордыг уурхай барьж ашиглалтад шилжүүлэх талаар ажиллаж байгаа юм. Танд тус ордтой холбоотой санаа зовинож байгаа асуудал байгаа юу?
Ангилал- аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчин, эдийн засаг, нийгэм

12. Танд ямар нэгэн нэмж дурдах зүйл байна уу?

Баярлалаа.

Таны үзэл бодол, санаанууд их ач холбогдолтой байсан бөгөөд таныг цаг гарган бид бүхэнтэй ярилцсан явдалд маш их талархаж байна.